

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС, АГЕНТЛАГ, СУМДЫН
2022 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2022.01.31

Сүхбаатар сум

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Тэргүүлэгчдийн үйл ажиллагааны талаар:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын VIII хуралдаан 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр цахимаар хуралдаж 1 асуудал хэлэлцэн 1 тогтоол баталлаа. Үүнд:

1.2022 онд үйлдвэрлэлийн болон ахуйн зориулалттай хэрэглээний мод, түлээ бэлтгэх хуваарийг батлах тухай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас Монгол Улсын шинэ “Үндсэн хууль” батлагдсаны 30 жилийн ойд зориулан Үндсэн хуулийг боловсруулж хэлэлцэн баталсан Ардын Их Хурлын Депутат, Улсын бага Хурлын гишүүд, уг ажилд оролцсон Ажлын хэсэг, зохион байгуулах комисс, эрдэмтэд, судлаачдад хүндэтгэл үзүүлэх, талархал илэрхийлэх, тэдний үйл хэргийг сурталчлах зорилгоор “Талархлын захидал”-ын уралдааныг зохион байгуулж, 15 иргэн захидал ирүүлснээс ТЭРГҮҮН байранд Сүхбаатар сумын 7-р багийн иргэн, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн оюутан Г.Дөлгөөн, ДЭД байранд Сүхбаатар сумын 2-р багийн иргэн, аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-ийн дарга Б.Болорзул, ГУТГААР байранд Мандал сумын 6-р багийн иргэн, Зүүнхараа политехник коллежийн багш Э.Бадмаараг нарын захидал тус тус шалгарсан.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Б.Нарантуяа шинэчлэн байгуулагдсан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих үүрэг бүхий “Иргэний зөвлөл”-ийн бүрэлдэхүүнийг хүлээн авч уулзан, энэ оны ажлын төлөвлөгөө, зорилго, зорилтын талаар санал солилцон, цаашид хийгдэх ажилд нь амжилт хүслээ. 3 жилийн хуулийн хугацаатай ажиллах иргэний зөвлөлд Ц.Отгонбаяр, Ч.Даваадорж, А.Отгонбаяр, С.Баяржаргал, Д.Бүрэнтөгс, Г.Дамдинсүрэн, Т.Доржсүрэн нар ажиллахаар сонгогдсон юм.

Дээрх иргэний зөвлөлийн бүрэлдэхүүнийг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн хурлаар хэлэлцэн 133 дугаар тогтоолоор томилох шийдвэр гарсан.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:

Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурал хуралдаж, 2022 оныг “БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ-НИЙГМИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ЖИЛ” болгон зарлаж, аймгийн Засаг даргын 2022 оны А/01 дүгээр захирамжийг гарган зарласан жилийн хүрээнд төлөвлөгөөг боловсруулан ажиллалаа.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн 2021 оны жилийн эцсийн тайланг Монгол Улсын Засгийн газарт хүргүүлэн ажиллалаа. Аймгийн хэмжээнд хяналтад авсан нийт 117 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 222 заалтын хэрэгжилтийг холбогдох хэлтэс, албадаас татан авч нэгтгэн боловсруулсан. Тогтоол шийдвэрийн хэрэгжилт **95.79** хувийн гүйцэтгэлтэй байна.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан санал, өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн 2021 оны жилийн эцсийн тайланг нэгтгэн боловсруулж, Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэн ажиллалаа. 2021 онд аймгийн хэмжээнд төрийн байгууллага, албан тушаалтанд нийт 5471 иргэн хандаж санал, хүсэлт, өргөдөл, гомдол гаргаснаас 5124 иргэний өргөдлийг хуулийн хугацаанд нь шийдвэрлэж хариу өгсөн нь **93.6** хувийн үзүүлэлттэй байна.

Сэлэнгэ аймгаас “Улсын Аварга малчин”, “Аварга фермер”, “Улсын аварга тариаланч хамт олон”, “Улсын аварга тариаланч” нар тодорлоо.

“Улсын аварга малчин”-аар:

- Алтанбулаг сумын Цөх багийн малчин Жамаагийн Пүрэв
- Жавхлант сумын Бумбат багийн малчин Содномын Зандан

“Улсын аварга фермер”-ээр:

- Баянгол сумын Гонир багийн фермер Маамын Адъяасүрэн
- Орхон сумын Бэлэн далай багийн фермер Баасанжавын Буянбат
- Хушаат сумын Даагат багийн фермер Дамдинсүрэнгийн Алтансүх

“Улсын аварга тариаланч хамт олон”-оор:

- Баруунбүрэн сумын “Ивэнтүрүү” ХХК;
- Цагааннуур сумын “Шүрэн тариа” ХХК;
- Орхонтуул сумын “Агрошим” ХХК;

“Улсын аварга тариаланч”-аар:

- Зүүнбүрэн сумын иргэн Дашчирэвийн Болортуяа;
- Хушаат сумын “Өгөөж мандал уул” ХХК-ий механикжуулагч Галбадрахын Энхбаяр нар шалгарч хөдөлмөр, зүтгэлээрээ улсдаа манлайллаа.

Ажил үйлсээрээ 2021 онд манлайлан тэргүүлсэн Сэлэнгэ аймгийн салбарын аваргуудын шагналыг гардуулан өглөө. Шагналыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Б.Нарантуяа, аймгийн Засаг дарга Н.Лхагвадорж, аймгийн Засаг даргын орлогч Ж.Сайнцог, Ц.Рэгзэдмаа нар гардууллаа.

“Тэргүүний хамт олон”-оор:

- Ерөө сумын Эрүүл мэндийн төв

“Төрийн Захиргааны аварга ажилтан”-аар:

- БШУГ-ын Бага боловсрол хариуцсан мэргэжилтэн Пүрэвийн Мягмарсүрэн

“Боловсролын салбарын аварга ажилтан”-аар:

- Мандал сумын Ерөнхий боловсролын 4-р сургуулийн Газар зүй, биологийн багш Даваасүрэнгийн Мөнхбаатар

“Эрүүл мэндийн салбарын аварга ажилтан”-аар:

- Мандал сумын Нэгдсэн эмнэлгийн эмчилгээ эрхэлсэн орлогч дарга Батсуурийн Чимгээ

“Эрүүл мэндийн салбарын аварга”-аар:

- Алтанбулаг сумын Эрүүл мэндийн төвийн бүртгэл мэдээллийн ажилтан Намжилын Найманжин
- Аймгийн Нэгдсэн эмнэлгийн сувилагч Ойдовын Энхжаргал

“Соёл урлагийн салбарын аварга ажилтан”-аар:

- Жавхлант сумын соёлын төвийн дарга Гэлдээгийн Бямбасүрэн

“Биеийн тамир спортын салбарын аварга ажилтан”-аар:

- Биеийн тамир спортын газрын арга зүйч Лхагвагийн Аззаяа

“Санхүү эдийн засгийн салбарын аварга ажилтан”-аар:

- Ерөө сумын Ерөнхий боловсролын сургуулийн нягтлан бодогч Рэнпилийн Дариймаа

“Худалдаа үйлчилгээний салбарын аварга ажилтан”-аар:

- Сүхбаатар сумын “Нарлаг Сэлэнгэ мөрөн” ХХК-ий захирал Баярринченгийн Одончимэг

“Үйлдвэрлэлийн салбарын аварга ажилтан”-аар:

- Мандал сумын “Мон зуу шаглаа” ХХК-ий оёдолчин, эсгүүрчин Намнансүрэнгийн Октябрь

“Дэд бүтцийн салбарын аварга ажилтан”-аар:

- Мандал сумын “Цант-Орхон” ОНӨААТҮГ-ын техникч Чойдогийн Батцэнгэл
- Аймгийн Нэгдсэн эмнэлгийн тоног төхөөрөмжийн техникч Дашдоржийн Отгонбаатар

“Хууль хяналтын салбарын аварга ажилтан”-аар:

- Аймгийн Өмгөөлөгчдийн зөвлөлийн дарга, өмгөөлөгч Рэнцэндоржийн Атарцэцэг

“Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын аварга ажилтан”-аар:

- Ой баясах ХХК-ий захирал Банзрагчийн Эрдэнэчимэг

“Тэргүүний сурагч”-аар:

- Улсын Тэргүүний ерөнхий боловсролын Лаборатори 4 дүгээр сургуулийн 12б ангийн сурагч Отгончулууны Нандин-Эрдэнэ /сурлага/
- Улсын Тэргүүний ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 12г ангийн сурагч Одмаагийн Очгэрэл /урлаг/
- Улсын Тэргүүний ерөнхий боловсролын Лаборатори 4 дүгээр сургуулийн 10а ангийн сурагч Баянмөнхийн Амин-Эрдэнэ /спорт/

УИХ-ын гишүүн Д.Өнөрболор Сэлэнгэ аймгийн эрүүл мэндийн салбарт нэн шаардлагатай байсан иж бүрэн 42 компьютерийг хүлээлгэн өглөө.

Аймгийн Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг Сүхбаатар суманд ажиллаж, тус суманд 2021 онд хийгдсэн 1-р багийн өрхийн эмнэлгийн байрны засвар, 2 дугаар багийн байр, 3 дугаар багт ашиглалтад орсон хүүхдийн цэцэрлэг, 4 дүгээр багийн 3-р цэцэрлэгийн барилгын засвар, 4, 8 дугаар багт шинээр хийгдсэн инженерийн шугам сүлжээ зэрэг хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлын гүйцэтгэл, Сэлэнгэ Энерго” ОНӨААТҮГ, Ганзам 7-р багт байрлах ашиглагдахгүй байгаа хүүхдийн цэцэрлэг, тус багт байрлах балгас болсон барилгын суурь, Хонгорморьт 1-р багт байрлах нэгдсэн хогийн цэг, Салхит 3-р багийн гэрэлтүүлэг, аймгийн угтаж үдэх Сүхбаатар хаалга зэрэг газруудаар ажиллалаа.

Аймгийн Онцгой комиссын үйл ажиллагааны талаар:

Аймгийн Онцгой комиссын Шуурхай штабаас дэлхийн дахинд тархаад буй коронавирус /Ковид-19/-ын халдварын тохиолдол гарч, халдварлах эрсдэл бий болсонтой холбоотойгоор урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах чиглэлээр Онцгой комиссын орлогч, Шуурхай штабын дарга, аймгийн Засаг даргын орлогч Ц.Рэгзэдмаагаар ахлуулсан Онцгой байдлын газрын 7, Цагдаагийн газрын 1, Мэргэжлийн хяналтын газрын 4, Эрүүл мэндийн газрын 1 нийт 13 албан хаагч өглөөний **09:00-21:00** цаг хүртэл ажиллан аймгийн Онцгой комиссын даргаас хийж хэрэгжүүлэх ажил, арга хэмжээний талаар өгсөн үүрэг чиглэл, мэргэжлийн байгууллагуудаас хэрэгжүүлсэн арга хэмжээ, нөхцөл байдлын мэдээллийг хүлээн

авч холбогдох шийдвэрийг гаргаж, сумдын Онцгой комиссын дарга нарт үүрэг чиглэл хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Аймгийн Онцгой комисс 3 удаа хуралдан 24 асуудлыг хэлэлцэж 32 асуудлыг шийдвэрлэн аймгийн Засаг даргын захирамж 2, тогтоол 3, хурлын тэмдэглэл 3-г гарган албажуулсан.

Шуурхай штабын **70363684, 70360119** дугаарын утсанд 120 мэдээлэл, цахим хаягаар 112 албан бичиг нийт 232 мэдээлийг хүлээн авч шийдвэрлэсэн байна.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын цахим хуудас болон Онцгой байдлын газрын цахим пэйж хуудсанд Онцгой байдлын газар, ДЗМОУБ-тай хамтран “Яагаад амны хаалт зүүх ёстой вэ?”, “Гараа яагаад угаах ёстой вэ?”, “Хамтын хүчээр халдвараас сэргийлье”, “Ковидгүй Сэлэнгийн төлөө” шторк, аймгийн Онцгой комиссын мэдээ, мэдээллийг **15** удаа байршуулж, **25100** хандалт авсан.

Мөн орон нутагт үйл ажиллагаа явуулж буй хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран цаг үеийн нөхцөл байдлын талаарх мэдээллийг шуурхай бэлтгэн аймгийн Засаг даргын Тамгын газраас “Сэлэнгэ аймаг АЗДТГ”, “Сэлэнгэ Цахим телевиз” цахим хуудас, “Зиндаа.мн” сайт, “Улс төрч.мн” сайт, Сүхбаатар сум дахь лед дэлгэц, орон нутгийн “Миний Монгол ТВ”, “Таны Сэлэнгэ ТВ” мөн МҮОНТ-ийн ММ агентлаг, Өлзий телевиз, Монцамэ агентлаг зэрэг мэдээллийн сувгуудаар мэдээ, мэдээллийг дамжуулан, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Улсын Онцгой комиссын Нэгдсэн шуурхай штаб, Онцгой байдлын ерөнхий газарт тухай бүр мэдээлэл хүргүүлэн ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлын 1 дүгээр давлагаанд **217**, 2 дугаар давлагаанд **4849**, 3 дугаар давлагаанд **13783**, 4 дүгээр давлагаанд **5145** нийт **23994** тохиолдолд батлагдаж 2022 оны 01 дүгээр сарын байдлаар **20833** иргэн эдгэрч, **58** хүн нас барж, 6 эмнэлгийн 12 ковидын эмчилгээний тасагт **268** иргэн хэвтэн эмчлүүлж, гэрийн эмчилгээнд **2804** иргэн өрх болон сум, тосгоны Эрүүл мэндийн төвийн хяналтад байна. **23994** тохиолдол батлагдсанаас ойрын хавьтал **11846**, дам хавьтал **5707**, нийт **17553** ойрын болон дам хавьтал тогтоогдож байна.

Хэвтэн эмчлүүлж байгаа иргэдээс маш хүнд **0**, хүнд **2**, хүндэвтэр **54**, хөнгөн - **212**, үүнээс жирэмсэн **16**, 0-17 насны **44** хүүхэд байна.

01 дүгээр сарын байдлаар коронавируст халдвар /ковид-19/-ын 5048 тохиолдол шинээр бүртгэгдэж, 2311 хүн эдгэрч, 1 нас баралт бүртгэгдэж, сүүлийн 2 сарын хугацааг харьцуулж үзвэл батлагдсан тохиолдол **84 хувь** өссөн байна.

Аймгийн хэмжээнд өссөн дүнгээр I тун **70175**, II тун **66107**, III тун **36167**, IV тун **3765** тус тус хийгдээд байна.

Аймгийн Онцгой комиссын шийдвэрээр аймгийн Нэгдсэн эмнэлгээс коронавирусын батлагдсан тохиолдлын насанд хүрэгчид болон хүүхдийн амбулаторийг ажиллуулж эхэллээ.

Энэ хугацаанд 23 хяналтын цэгт давхардсан тоогоор 600 Цагдаагийн газрын албан хаагч 23 тээврийн хэрэгсэлтэй, Онцгой байдлын газрын 900 алба хаагч, Эрүүл мэндийн байгууллагын 1470, Мэргэжлийн хяналтын газрын 30 бусад төрийн байгууллагуудтай хамтран нийт 3000 албан хаагч үүрэг гүйцэтгэсэн.

“Коронавируст /Ковид-19/-ын халдварт цар тахлаас урьдчилан сэргийлэх талаар аж ахуйн нэгж, байгууллагуудад дагаж мөрдөх журам”-ын хүрээнд аж ахуйн

нэгж, байгууллагуудад халдвар хамгааллын дэглэмийг сахиулж, ариутгал халдваргүйжүүлэлтийг тогтмол хийлгэн журмыг мөрдүүлэн ажиллаж байна.

Аймгийн хэмжээнд **1380** цэг байршилд **647,277** м2 талбайд урьдчилан сэргийлэх болон голомтын эцсийн халдваргүйжүүлэлтийг хийж гүйцэтгэсэн.

“Тавт” шалгалт хамгаалалтын заставын хариуцсан хэсэг, улсын хилээр нийт 330 галт тэрэгний 676 хөлөг ажилтан, 13081 тээврийн хэрэгслийг зохих журмын дагуу шалган нэвтрүүлсэн.

“Алтанбулаг” хилийн боомтоор 2022 оны 01 сарын байдлаар зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөн:

Зорчигч			Тээврийн хэрэгсэл		
Орох чиглэлд	Гарах чиглэлд	Нийт	Орох чиглэлд	Гарах чиглэлд	Нийт
1577	1509	3086	1069	1068	2137

Аймгийн хэмжээнд мал, амьтны гоц халдвар “Шүлхий” өвчин бүртгэгдсэн 4 сум хязгаарлалт цуцлагдаж, 4 суманд хязгаарлалтын дэглэм үргэлжилж байна.

Өвчлөл бүртгэгдсэн өдрөөс эхлэн нийт **420** өрхийн **2062** хонь, **214** ямаа, **4913** үхэр нийт **7189** мал, амьтанд гоц халдварт А01 өвчний шинж тэмдэг илэрч, ээмэгжүүлэн бүртгэлжүүлсэн.

Улсын Онцгой комисс болон Мал эмнэлгийн ерөнхий газраас 7 удаагийн татан авалтаар **760000** тун вакцин хүлээн авч өссөн дүнгээр **6241** өрхийн **233184** үхэр, **1042786** бог, **4971** гахай, **23** тэмээ нийт **1280964** толгой мал, амьтныг вакцинжуулалтад хамруулж, вакцинжуулалт **99,7** хувьтай хийгдсэн.

Нийт **4494** малын хашаа хороо, тоног хэрэгсэл, бэлчээрийн **1192494** м2 талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн.

Онцгой байдлын ажил үйлчилгээний талаар:

Аймгийн хэмжээнд мал амьтны гоц халдварт “Шүлхий” өвчний дуудлага **4**, объектын гал түймэр **13** удаагийн дуудлагаар тус тус гарч ажилласан.

Онцгой байдлын газрын үйлчлэх хүрээний нутаг дэвсгэрт объектын гал түймрийн 13 дуудлага бүртгэгдэж нийт 64,000,0 сая төгрөгийн хохирол учирч гал түймэр унтраахад 50,9 тн ус, 332,58 л шатахуун зарцуулж, иргэн, аж, ахуйн нэгж байгууллагын 48,000,0 сая төгрөгийн өмч хөрөнгийг гал түймрийн аюулаас авран хамгаалсан байна.

МУЗГ-ын 2021 оны 57 дугаар хуралдааны шийдвэрийн хэрэгжилтийг хангах, аймгийн нутаг дэвсгэрт шинэ жилийн баяр тэмдэглэх, хүлээн авалт зохион байгуулах иргэн, хуулийн этгээдийн барилга байгууламжийн галын аюулгүй байдлыг хангуулах, үзвэр үйлчилгээ, томоохон худалдааны төв, захуудад пиротехникийн хэрэгсэл худалдан борлуулж байгаа байдалд хяналт тавих, тухайн байгууллагын галын аюулгүй байдлыг хангуулах, мөн гэр хорооллын багуудын айл өрхийн галын аюулгүй байдлыг хангуулах зорилгоор нэгдсэн арга хэмжээг зохион явуулсан

Нэгдсэн арга хэмжээний хугацаанд Сүхбаатар, Мандал, Баянгол, Сайхан сум дахь Гал түймэр унтраах, аврах анги, Эрэн хайх, аврах ангийн бие бүрэлдэхүүн сумдын ЗДТГ-аас болзошгүй гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, пиротехникийн хэрэгсэл /салют/ ашиглахгүй байх, ашиглах тохиолдолд

аюулгүй байдлыг хангаж хэрэглэх, цахилгаан хэрэгсэл, хийн баллоны аюулгүй байдлыг хангах талаар 510 айл өрхийн пийшин зуух, цахилгаан хэрэгсэл, хийн плитка, өвс хадлан тэжээл, өвөлжөө хашаа саравчийг үзэж, шалган дээрх өрхийн 1840 иргэнд илэрсэн зөрчил дутагдалыг арилгах, аюулгүй байдлаа хангах талаар заавар зөвлөмж өгч хангуулсан.

Тус арга хэмжээний хүрээнд иргэд олноор цуглардаг худалдаа, үзвэр үйлчилгээ, гудамж талбай, айл өрхүүдээр албан хаагч нар явж иргэдэд болзошгүй гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, мөсөн дээгүүр зорчихгүй байх, пиротехникийн хэрэгслийг ашиглахгүй байх, цахилгаан хэрэгслийн аюулгүй байдлыг хангах зэрэг сэдэв бүхий 1500 ширхэг сэрэмжлүүлгийн материалыг тараан ажилласан.

Сүхбаатар, Мандал, Сайхан, Баянгол сумдын кабелийн телевизээр 20-25 удаагийн давтамжтайгаар болзошгүй гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх шторк сэрэмжлүүлгийг нэвтрүүлж, аймгийн Онцгой байдлын газрын sea.nema.gov.mn, “Сэлэнгэ Онцгой байдлын газар” фэйсбүүк хуудсанд 8 удаагийн сэрэмжлүүлэг мэдээллийг байршуулж, орон нутгийн “Миний Монгол” КаТв-ээр гол, нуурын мөс цөмрөх, гэр хорооллын гал түймрийн аюул, пиротехникийн хэрэгслийг ашиглахгүй байх талаар урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг ярилцлагыг 1 удаа нэвтрүүлсэн.

Тайлант үед 1 байгууллагаас ирүүлсэн хүсэлтийн дагуу 15 объектод хяналт шалгалт зохион байгуулж 32 зөрчил илрүүлж, 15 объектод ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт олгож 1,500,0 төгрөгийн хураамжийг аймгийн төрийн сангийн дансанд төвлөрүүлж ажиллалаа.

Мэргэжлийн хяналтын үйл ажиллагааны талаар:

Коронавируст халдвар /Ковид-19/ цар тахлын үед нийтээр тэмдэглэх баярын өдрүүдийг тохиолдуулан Сүхбаатар, Сайхан сумдад үйл ажиллагаа явуулж байгаа махны худалдаа эрхлэгч 19, хүнсний худалдаа үйлчилгээний 102, хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхлэгч 8, хүнсний үйлдвэрлэл 1, төмс, хүнсний ногооны худалдаа эрхлэгч 7, жимс, жимсгэний худалдаа эрхлэгч 10, зочид буудлын үйл ажиллагаа эрхлэгч 7, жолооны сургалтын төв 3, бүжгийн сургалтын төв 1, шашин, сүм хийд 2, солонгос хэлний сургалтын төв 1, нийт 154 объектыг хамруулан 129 зөрчлийг илрүүлж 65 буюу 50 хувийг газар дээр нь арилгуулж, коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллах талаарх улсын байцаагчдын 74 заалттай 5 зөвлөмжийг 154 аж ахуйн нэгж, иргэнд хүлээлгэн өгч биелэлтийг тооцож ажиллалаа.

Хөдөө аж ахуйг дэмжих Сангийн Хөтөл салбарын 2022 оны 03 дугаар хүсэлтийн хүрээнд 2021 оны ургацаас нөөцөлсөн 5 сортын 2787 тонн тарих үрийн буудайнаас зохих журмын дагуу 80 ширхэг дээжийг авч аймгийн Мэргэжлийн хяналтын газрын итгэмжлэгдсэн лабораторид чанар, аюулгүй байдлыг баталгаажуулахаар шинжилгээнд хамруулан ажиллаж, аймгийн Прокурорын газрын 2022 оны 1/76 дугаар бичгээр харьяалалын дагуу шилжилж ирсэн 1100-0043 дугаар зөрчлийн гомдлыг хүлээн авч танилцаж, холбогдогч Түшиг сумын 3 иргэнийг хялбаршуулсан журмаар 60.0 төгрөгийн шийтгэврийн арга хэмжээ авч, илэрсэн дутагдлыг арилгуулахаар хугацаатай үүрэг даалгавар өгч хэрэгжилтэд хяналт тавьж, “Спирт бал бурам” ХХК-иас ирүүлсэн хүсэлтийн дагуу Шимийн

архины үйлдвэрлэх үйл ажиллагаанд урьдчилсан хяналт хийж улсын байцаагчдын хамтарсан 2022 оны 18-03-011/02 дугаартай дүгнэлт гаргаж ажиллалаа.

Стандарт, хэмжил зүйн үйл ажиллагааны талаар:

Үйлчилгээний баталгаажуулалт: Сүхбаатар, Алтанбулаг, Ерөө, Хүдэр, Сайхан, Мандал, Баянгол, Шаамар, Цагааннуур сумдын 30 аж ахуйн нэгж, иргэний 17 хүнсний дэлгүүр, 2 минимаркет, 4 караоке баар, 1 худалдааны агуулах, 4 зоогийн газар, 1 алжаал тайлах бариа заслын үйлчилгээ, 1 хүнсний мухлагийн үйлчилгээнд МУ-ын “Худалдааны газар, түүний үйлчилгээ үндсэн шаардлага MNS 5021:2007”, “Хоолны газрын ангилал, зэрэглэл. Үндсэн шаардлага MNS 4946:2005”, “Хэрэглэгчдэд зориулсан үйлчилгээ. Алжаал тайлах бариа заслын үйлчилгээ. Ерөнхий шаардлага MNS 6922:2021”, “Худалдааны агуулах. Ерөнхий шаардлага MNS 5364:2011” стандартын шаардлагын дагуу тохирлын үнэлгээ хийж, тохирлын гэрчилгээг 1-2 жилийн хугацаатай олголоо.

Бүтээгдэхүүн баталгаажуулалт: Сант сумын “Ивэн” ХХБ цехийн “Цондгор бууз”, “Цондгор банш”, Сүхбаатар сумын “Мон-Апи” ХХК-ий үйлдвэрлэсэн Зөгийн балтай “Нарсхан” бальзам, Халгайтай бальзам, Мөрөөдлийн ханд (шимийн архи), Аньс, Нэрс, Чацарганы жүүс, Шидэт бальзам, Халгайн джем, Мандал сумын “Манна” цехийн үйлдвэрлэсэн “Манна” нэрийн кимчи зэрэг 3 нэрийн 11 бүтээгдэхүүнийг Мэргэжлийн хяналтын газрын итгэмжлэгдсэн лабораторид сорилт шинжилгээнд оруулж, шинжээчийн дүгнэлт гаргасан бөгөөд бүтээгдэхүүний сав баглаа боодол, хаяг шошгыг стандартын шаардлага хангасан зөв мэдээллээр хангаж арга зүйн заавар зөвлөмж өгч ажиллалаа.

Стандартын салбар сангаас **8** аж ахуй нэгж байгууллага, иргэний захиалгын дагуу **7** нэрийн **8** стандартын борлуулалт хийсэн.

Эзлэхүүн хэмжлийн төрлөөр: Эмнэлэгийн **34** ширхэг дулаан, даралтны аппарат шалган баталгаажуулж, **20** шилэн хэмжүүрт шалгалт тохируулга хийсэн.

Механик хэмжлийн төрлөөр: Массын хэмжих төрлөөр Сүхбаатар сум дахь худалдаа үйлчилгээнд ашиглаж байгаа **77** жинг шалган баталгаажуулалт, эмнэлэгийн лабораторын **2** жинд шалгалт тохируулга хийлээ.

Цахилгааны хэмжлийн төрлөөр: Цахилгаан хэмжлийн лаборатори 1 фазын **143** ширхэг тоолуур шалган баталгаажуулж, 1 аж ахуй нэгжтэй баталгаажуулалтын гэрээ байгуулсан байна.

Хоёр. Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

Тус сард 1000 баримтаар 26,6 тэрбум төгрөгийн төсөвт байгууллагуудын төлбөр тооцоог хянан гүйцэтгэлээ.

Аймгийн ИТХ-ын 2021 оны 25 дугаар тогтоолоор батлагдсан аймгийн 2022 оны төсөв, аймгийн Засаг даргын 2021 оны А/414 тоот захирамжаар батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийг төсвийн Фискал программд шивж, Сангийн яаманд хүргүүлэн ЗГСУМС-д татуулан ажиллалаа.

Аймгийн 12 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн нэгдсэн мэдээг гаргаж Статистикийн хэлтэст хугацаанд нь хүргүүлж, мөн сарын аймгийн орлогын гүйцэтгэлийн мэдээг Татварын хэлтэстэй тулган баталгаажуулж, төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр аймгийн web сайт, шилэн данс болон ил тод самбарт байршуулан ажиллаж байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг сум бүрд хуваарилан тавьж, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт олгосон.

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл		2020 - XII	2021 – XII	<u>2021 - XII</u> <u>2020 - XII</u>
1.ХҮНСНИЙ БАРАА				
1	Талх, гурил, будаа			
	Гурил /савласан, кг/	1 300	1 500	115.4
	Талх /орон нутгийн, ш/	1 316	1 400	106.4
	Нарийн боов /кг/	2 533	4 300	169.8
	Будаа /кг/	2 633	3 000	113.9
	Элсэн чихэр /кг/	2 466	3 000	121.7
2	МАХ МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН			
	Хонины мах /кг/	6 800	8 500	125.0
	Үхрийн мах /кг/	7 800	9 500	121.8
	Адууны мах /кг/	7 250	7 500	103.4
	Ямааны мах /кг/	6 500	7 500	115.4
	Дотор мах, цувдай /цусгүй/	4 000	5 000	125.0
	Хиам /чанасан, кг/	10 666	12 500	117.2
3	СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ			
	Сүү /задгай, л/	1 500	2 200	146.7
	Сүү / савласан, л/	3 200	3 500	109.4
	Тараг /задгай, л/	1 700	2 500	147.1
	Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	15 500	22 500	145.2
	Айраг /л/	4 000	5 000	125.0
	Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/	8 650	5 500	63.6
	Өндөг /ш/	466	450	96.6
4	Бүх төрлийн өөх тос			
	Ургамлын тос /л/	4 500	7 500	166.7
	Өөхөн тос /кг/	2 500	3 000	120.0
	Шар тос /кг/	15 000	25 000	166.7
	Масло /задгай, кг/	4 500	6 000	133.3
5	ХҮНСНИЙ НОГОО			
	Төмс /кг/	933	1 000	107.2
	Лууван /кг/	1 366	2 500	183.0
	Манжин /кг/	1 600	2 500	156.3
	Байцаа /кг/	1 500	2 300	153.3
	Сонгино /кг/	2 500	2 500	100.0
	Өргөст хэмх /шилтэй, дарсан/	4 566	6 000	131.4
	Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	3 016	4 000	132.6
2. ШАТАХУУН				
	Бензин А - 80 /шунхлай/	1 400	2 300	164.3
	Бензин А - 92 /шунхлай/	1 470	2 330	158.5

Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

Аймгийн Засаг даргын 2022 оны “Монгол Улсын Үндсэн хууль батлагдсаны 30 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх тухай”А/06 дугаар захирамжийг батлуулан хэрэгжүүлж ажилласан. Захирамжийн хүрээнд Ардын Их Хурлын депутатуудад хүндэтгэл үзүүлэх, шатрын тэмцээн, сургалт, сурталчилгааны ажил зэргийг аймгийн хэмжээнд зохион байгууллаа.

Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэн, олон нийтийг соён гэгээрүүлэх, төрийн үйлчлэгээний ил тод байдлыг нэмэгдүүлэх, хариуцлагыг дээшлүүлэх, авлигатай тэмцэх хүсэл эрмэлзлэлийг нэмэгдүүлэх, захирах захирагдах ёсны зарчмыг хэрэгжүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шалтгаан нөхцлийг арилгуулах, ажлын үр дүнг дээшлүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2021 оны А/292 дугаар захирамжаар батлагдсан “Шударга удирдагч, шударга төрийн албан хаагч” аяны удирдамжийг сум, агентлагуудад хүргүүлэн, хэрэгжүүлэх ажлыг эхлүүлээд байна.

2022 оны хувийн ашиг сонирхол хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах албан тушаалтнуудын нэрсийн жагсаалтыг харьяа сум, агентлагуудаас авч нэгтгэн Авлигатай тэмцэх газарт аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2022 оны 02/10 тоотоор хүргүүлсэн.

Цагдаагийн газар: Аймгийн хэмжээнд 2022 оны эхний 1 сард 15 холбогдогчтой 386.9 сая төгрөгийн хохиролтой 85 гэмт хэрэг бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 39 хэргээр буюу 84.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Гэмт хэргийн илрүүлэлт 8.2 хувьтай байгаа нь өмнөх оноос 5.6 хувиар өссөн байна. Үүнээс “Хүний амьд явах эрхийн эсрэг гэмт хэрэг” 2.5 дахин, “Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг” 1.9 дахин, “Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг” 2.1 дахин, “Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг” 2 хэргээр, “Цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг” 2 хэргээр, “Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг” 5 хэргээр өмнөх оны мөн үеэс тус тус өссөн байна.

Аймгийн хэмжээнд 2022 оны эхний 1 сард **2203** зөрчил илрүүлсэн нь 1620 зөрчлөөр буюу 3.7 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Нийт зөрчлийн 1980 буюу 89.8 хувийг Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих /14.7/, 223 буюу 10.2 хувийг бусад зөрчил эзэлж байна.

Зөрчилд 2069 хүнийг 90.765.000 төгрөгөөр торгож, 21 хүнийг шүүгчийн шийтгэврээр баривчлуулсан байна.

Согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 61 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасч, торгосон.

Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 4 дахин, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэрэг 3.5 дахин, урьд ял шийтгэгдсэн хүмүүсээс үйлдсэн гэмт хэрэг 33,3 хувиар, хүүхэд оролцсон гэмт хэрэг 1 хэргээр тус тус өссөн.

Бүртгэгдсэн нийт гэмт хэргийн 14.1 хувь, зөрчлийн 72.7 хувийг согтуугаар үйлдэж, гэмт хэргийн 8.2 хувь, зөрчлийн 12.5 хувийг гэр бүл, хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн байна.

Нийт гэмт хэргийн дийлэнх буюу 29.4 хувийг 06-14 цагт, зөрчлийн 53.8 хувийг 13-18 цагт тус тус үйлдэж, гэмт хэргийн 37.6 хувь нь Мягмар, Баасан гарагт, зөрчлийн 36.9 хувь нь Даваа, Мягмар гарагт тус тус үйлдэгдсэн байна.

Гэмт хэргийн 45.8 хувь, зөрчлийн 29.0 хувь, эрүүлжүүлэгдсэн хүний 77.0 хувь гэр, орон сууцанд, ахуйн хүрээнд үйлдэгдэж байгаа нь хэрэг, зөрчлийн дийлэнх хувийг эзэлж байна.

Улсын бүртгэлийн хэлтэс: Иргэний бүртгэлийн талаар дараах үйлчилгээгээр үйлчилсэн.

- Төрсний бүртгэл - 105 /эрэгтэй-49, эмэгтэй-51/
- Гэрлэлтийн бүртгэл - 44
- Гэрлэлт цуцалсны бүртгэл - 9
- Үрчлэлт - 5
- Эцэг тогтоолт - 2
- Овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл - 9
- Нас баралт - 58
- Нийт олгосон иргэний үнэмлэх - 323
- Шинээр олгосон иргэний үнэмлэх - 136
- Дахин олгосон иргэний үнэмлэх - 32
- Иргэний үнэмлэхийн хугацаа дуусч солиулсан - 155
- Гадаад паспорт олголт - 28
- Аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн – 149
- Хот доторх шилжилт хөдөлгөөн - 164 тус тус бүртгэгдсэн байна.

Дөрөв. Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

Боловсрол, соёл урлаг, спортын талаар: Боловсролын салбарын төсөв цахимд шилжиж БШУЯ-аас хуваарилагдан, санхүүжигдэж байгаатай холбогдуулан аймагтаа төсвийн шинэчлэлийн хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалт, мэргэжил арга зүйгээр хангах чиг үүрэг бүхий дэд ажлын хэсгийг аймгийн Засаг даргын А/13 тоот захирамжаар байгуулан, хэрэгжилтийг хангуулахаар ажиллаж байна.

“Бидний хөтөч-Эдмодо платформ” төслийн хүрээнд бага ангийн багш нарын дунд цахим хичээл, цахим хэрэглэгдэхүүн, аудио хичээлийн уралдааны удирдамжийг сургуулиудад хүргүүлсэн бөгөөд 2 дугаар сарын 25 хүртэл 2 үе шаттай зохион байгуулагдана.

“Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системийн мэдээллийн шинэчлэх ажлыг гүйцэтгэлээ.

Монголын англи хэлний багш нарын холбоо нь Олон Улсын байгууллагуудтай хамтран 9 долоо хоногийн турш ЕБС-ийн англи хэлний багш нарын хэлний түвшин ахиулах сургалтыг зохион байгууллаа.

Япон Улсын шинжлэх ухаан, технологийн агентлагаас Ази, Номхон далайн бүсийн орны ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдад зориулсан “Сакура” шинжлэх ухааны хөтөлбөрийн хүрээнд “Chuo” их сургуулийн үйл ажиллагаатай танилцах, их, дээд сургуулийн тэргүүлэх эрдэмтдийн лекцийг сонсох, Япон Улсад сурах боломжийн талаар мэдээлэл өгөх онлайн арга хэмжээнд 10-12-р ангийн 68 сурагчдыг хамруулахаар бэлтгэлийг хангалаа.

Соёл урлагийн газар шинээр байгуулагдаж байгаатай холбогдуулан хуулийн этгээдийн холбодох баримт материалыг боловсруулж холбогдох газар саналаа уламжлан шийдвэрлүүлээ.

Аймгийн соёл урлагийн 26 байгууллагын 2022 оны төсвийн сар, улирлын хуваарийг төлөвлөн боловсруулж, холбогдох яам, байгууллагуудад хүргүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллалаа.

Эрүүл мэндийн талаар: Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн шинжээчид Зүүнбүрэн, Түшиг сум, Бугант тосгоны Эрүүл мэндийн төвүүдэд үнэлгээг цахимаар өгөх ажлыг зохион байгууллаа.

Улсын Онцгой комиссын 2021 оны 06 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны “Гадаад улсаас ирсэн хүнийг тусгаарлан ажиглах үйл ажиллагааг зохицуулах түр журам батлах тухай” 69 дүгээр тушаалыг баримтлаж, Сүхбаатар суманд 2, Алтанбулаг суманд 1 тусгаарлан ажиглах байрыг ажиллуулж, 306 иргэнийг тусгаарлан, шинжилгээ авах ажлыг зохион байгууллаа.

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 01, 02 тоот албан даалгаврыг тус тус үндэслэн “Коронавируст халдвартай хүүхэд, насанд хүрэгчдэд эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх амбулатори”-г аймгийн Нэгдсэн эмнэлэг, Мандал сумын Нэгдсэн эмнэлгийг түшиглэн зохион байгуулж, 2 амбулаториор нийт 71 иргэн үйлчлүүлсэн ба үүнээс дотрын эмч, 58 иргэн, хүүхдийн их эмч 13 хүүхдэд эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлсэн байна.

Коронавирусын халдварын тохиолдол нэмэгдсэнтэй холбоотойгоор аймгийн хэмжээнд Ерөө, Баянгол, Шаамар сумдын эрүүл мэндийн төвүүдэд коронавирусын халдварыг эмчлэх тасгийг нээн ажиллуулснаар иргэдэд эрүүл мэндийн тусламжийг шуурхай хүргэх ажлыг зохион байгууллаа.

Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал, нийгмийн даатгалын хүрээнд:

01 дүгээр сард 64022 иргэнд зориулсан 14 төрлийн халамжийн үйлчилгээнд 6250929,2 мянган төгрөгийг зарцууллаа.

Халамжийн санд улсын төсвөөс тайлант хугацаанд 64020 иргэнд 6248529.2 мянган төгрөгийг олголоо. Үүнд:

1. Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2288 иргэнд 421240.9 мянган төгрөг
2. Нийгмийн халамжийн тэтгэмжид 1637 иргэнд 137808.3 мянган төгрөг
3. Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмжид 287 иргэнд 48181.5 мянган төгрөг
4. Жирэмсэн эхийн тэтгэмжид 561 эхэд 21318.0 мянган төгрөг
5. 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж 4550 эхэд 223486.1 мянган төгрөг
6. Ихэр хүүхдийн тэтгэмжид 1 иргэнд 2000.0 мянган төгрөг
7. Эхийн алдар одонгийн тэтгэмжид 8964 иргэнд 1146400.0 мянган төгрөг
8. Насны хишиг тэтгэмжид 5321 иргэнд 412940.0 мянган төгрөг
9. Ахмадын настанд олгох хөнгөлөлт, тусламжид 124 ахмадын 20996.3 мянган төгрөг
10. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх хөнгөлөлт, тусламжид 122 иргэний 10673.8 мянган төгрөг
11. Алдар цолтон ахмад настанд олгох хөнгөлөлт, тусламжид 25 иргэнд 3920.0 мянган төгрөг
12. Хүнсний эрхийн бичгийн 2451 иргэнд 28464.0 мянган төгрөг

13. Хүүхдийн мөнгөн тэтгэмжид 37687 иргэнд 3768700.0 мянган төгрөгийг тус тус зарцууллаа

Халамжийн санд орон нутгийн төсвөөс орон гэрийн хөнгөлөлт, тусламжид 2 иргэнд 2400.0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүллээ.

Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн системд идэвхтэй ажил хайгчаар 257 иргэн бүртгүүлсэн ба ажил олгогчоос ирүүлсэн сул чөлөөтэй 32 ажлын байрны захиалгын дагуу 15 иргэнийг ажилд зуучлан ажиллалаа. Зуучлагдсан ажлыг үйл ажиллагааны чиглэлээр нь авч үзвэл:

- ХАА-н салбарт - 2
- Захиргааны болон дэмжлэг үзүүлэх - 2
- Төрийн удирдлага ба батлан хамгаалах - 4
- Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа - 1

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн талаар: Мандал сумын Хүүхдийн ордон, Орхонтуул сумдын “Хүүхэд хөгжлийн төв”-ийн 5 төрлийн дугуйлангуудад нийт 38 хүүхэд танхимаар хичээллэлээ. “Цодгор хүү” аварга шалгаруулах шатрын тэмцээнийг 5 хүртэлх, 6-7 нас, 8-9 нас, 10-11 нас, 12-оос дээш насны ангилалаар зохион байгуулж, нийт 91 хүүхэд оролцлоо.

“Хүслийн хөтөч” хүүхэд хамгаалал, оролцооны клубээс “Google form application” ашиглан ерөнхий боловсролын 5 сургуулийн нийт 557 сурагчдын дунд нээлттэй асуулга явуулж, сурагчдад тулгамдаж буй асуудал, эрсдэл нөхцөлийг тодорхойлохоос гадна тэдний сэтгэл зүй, хөгжих орчны талаар дэлгэрэнгүй судалгааг авч боловсруулалт хийн дүгнэлт гаргаж цаашдын төлөвлөгөөндөө тусган ажиллахаар боллоо.

Хүүхдийн тусламжийн 108 утсанд 16 дуудлага бүртгэгдсэн дуудлага мэдээллийг хамтарсан багуудад шилжүүлэн мэргэжлийн удирдлагаар хангаж, хүүхдийн мөнгөн тэтгэмжээ авч чадахгүй байгаа 4 сумдын 21 хүүхдийн зөрчигдсөн эрхийг хангуулах арга хэмжээг авч ажиллалаа.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс нь хуралдаж, нийт 40 хүүхдийн асуудлыг шийдвэрлэлээ.

17 сум 6 тосгоны хамтарсан багаар дамжуулан “Бүтэн өнчин хүүхдийн нөхцөл байдалд үнэлгээ хийж, 101 хүүхдийн нөхцөл байдлын судлагааг хийж мэдээллийг холбогдох газарт уламжиллалаа.

“Дэлхийн Зөн Монгол” ОУБ-ын Сэлэнгэ хөтөлбөртэй хамтран Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн дунд зохион байгуулсан “Илүү дээр маргаашийг хамтдаа бүтээцгээе” аяныг дүгнэж, эхний 3 байрыг шалгаруулж урамшууллаа.

Шүүгчийн захирамжийн дагуу хүүхдийн асран хамгаалагч тогтоох шинжээчийн дүгнэлтийг 2 өрхийн 3 хүүхдэд нөхцөл байдлын үнэлгээг хийлээ.

Азийн Хөгжлийн Банкнаас хэрэгжүүлж буй “Эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхыг дэмжих” төслийн 2 дугаар шатны сонгон шалгаруулалтад тэнцсэн 20 эмэгтэйд 4 өдрийн танхимын сургалт зохион байгуулж, төслийг хүргүүллээ.

Сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөө үйлчилгээг насанд хүрэгч 2, хүүхэд 6, нийт 8 иргэнд үзүүлсэн.

Тав. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хүрээнд:

Хөдөө аж ахуйн талаар: Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 8 дугаар тогтоолын дагуу сумдаас Улсын аварга малчин фермерт сумдаас ирүүлсэн материалыг шалгуур үзүүлэлтийн дагуу эрэмбэлэн улсын аваргын болзол хангасан Орхон, Зүүнбүрэн, Алтанбулаг, Баянгол, Мандал, Сант сумдаас ирүүлсэн “Аварга малчин”-ы 3 материал, “Улсын аварга фермер”-т 3, “Улсын хошой аварга” 1, “Аварга саалчин” 1, нийт 8 тодорхойлолтыг ХХААХҮЯ-нд хүргүүллээ.

Аймгийн хэмжээнд 17 сумын 56 багт 8903 малчин, мал бүхий өрхөд 1.800.387 толгой мал өвөлжихээр дүн мэдээлэл гарсан. Төв, Дархан-Уул, Орхон аймгуудаас 107 мал бүхий өрх, 65 малчин өрхийн 38,3 мянган толгой мал Баруунбүрэн, Баянгол, Ерөө, Зүүнбүрэн, Мандал, Орхонтуул, Сайхан, Хүдэр, Цагааннуур сумдад өвөлжиж байна.

Үндэсний 14 үйлдвэрт аймгийн 17 сумын 1370 малчин, мал бүхий иргэдийн тушаасан 1-р зэргийн 368707.1 кг, 2-р зэргийн 17755.4 кг ноосны 539,7 сая төгрөгний урамшууллын материалыг төсвийн урамшууллын системд оруулан ХХААХҮЯ-ны санхүү хөрөнгө оруулалтын газарт хүргүүлэн ажилласан.

206 иргэн, аж ахуйн нэгжийн урамшууллын материалыг бүрдүүлж, Хөдөө аж ахуйг дэмжих санд хүргүүллээ.

Сум хөгжүүлэх сангийн эргэн төлөлтийг эрчимжүүлж ажилласнаар 01 дүгээр сард 60.0 сая төгрөгийн эргэн төлөлтийг бүрдүүлсэн байна.

Мал эмнэлгийн үйлчилгээний талаар: Аймгийн Онцгой комиссын 2021 оны 37, 38 дугаар тогтоолоор аймгийн хэмжээнд Хорио цээрийн дэглэмийг эрчимжүүлэх, малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг эрчимжүүлж, шуурхай хариу арга хэмжээг зохион байгуулан ажиллаж, голомтын 8 сум, эрсдэл бүхий 8 сум, нийт 16 сумын **6241** өрхийн **1280964** толгой мал, амьтныг дархлаажуулалтанд хамруулж, нийт хуваарилж олгосон вакцины гүйцэтгэл 99.7 хувьтай байна.

Орхонтуул суманд 2021 оны 10 дугаар сарын 25-ны өдөр Төв аймгийн Цээл сумын хил залгаа орчимоор нутагладаг өрхөд малын гоц халдварт А01 өвчний сэжиг илэрч, 27-ны өдөр лабораторийн шинжилгээний дүнгээр баталгаажиж хорио цээрийн дэглэм тогтоон 70 хоног, сүүлд оношлогдсон Зүүнбүрэн суманд 43 хоног дэглэм тогтоон ажиллаж байна. 2022 оны 01 дүгээр сарын дуустал хугацаанд тус халдварт бэлчээр ус, хадлан тэжээл бэлтгэх, намрын ургац хураалт, үржлийн мал зөөвөрлөх зэрэг хөл хөдөлгөөний улмаас 8 сумын /Орхонтуул, Орхон, Сайхан, Сант, Баруунбүрэн, Хушаат, Жавхлант, Зүүнбүрэн/ 420 өрхийн 7189 толгой мал шүлхий өвчний ил шинж тэмдэгтэй өвчилж, үүнээс 9 мал хорогдож 420 өрхийн 7180 толгой малын ил шинж тэмдэг арилж, сүүлийн 24 цагийн хугацаанд голомтын хүрээ тэлээгүй, хорио цээр тогтоосон голомтонд шинж тэмдэг илэрсэн мал, амьтан байхгүй байна. 4 суманд хязгаарлалт цуцлагдаж хэвийн горимд шилжсэн, 4 суманд хязгаарлалтын дэглэм үргэлжилж байна.

Аймгийн хэмжээнд халдваргүйтгэлийн ажлыг машин, техник ашиглан уусмал найруулан зохион байгуулахад хүндрэлтэй болж, гадна температур -20 аас -35 хүрч байна. Голомтын өвөлжөө, хашааг уурын мананцаржуулагчаар халдваргүйтгэж, 792 ш өвөлжөө, хашаа хорооны 564330 м², 145 ш гахайн байрны 18670 м², 3265 ш тээврийн хэрэгслийн 75740 м², 11 ш түүхий эд хадгалах зоорины 6800 м², 66 ш худаг уст цэгийн 16300 м², 84 ш хэвтэр өтөг бууцны 61780 м², 28305 м² бэлчээр, голомтын болон устгалын бүсийн 94680 м² талбай, 207 ш

нийтийн эзэмшлийн талбайн 325889 мкв, бүгд 1192494 мкв талбайд халдваргүйтгэл хийгдээд байна. Сум тус бүрт Засаг даргын захирамжаар мэргэжлийн баг томилгоожин, мэргэжлийн зааварчилгаан дор үзлэг тандалт хийж идэвхтэй 6002 өрхийн 1260308 толгой мал, амьтан, идэвхгүй 17900 өрхийн 1498000 толгой мал, амьтны хамруулсан.

Уг өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор давхардсан тоогоор 583 малчид иргэдэд сургалт заавар зөвлөгөөг газар дээр нь болон мэдээллийн сувдгуудаар өгөн, мэргэжил арга зүйгээр хангаж, ажиллалаа.

Хүнсэнд: 606 гэрчилгээгээр адуу 103 , үхэр 199, хонь 644, ямаа 358, гахай 20 буюу нийт 1324 толгой мал, амьтан, 108371кг мах, махан бүтээгдэхүүн, 242223кг сүү, сүүн бүтээгдэхүүн,3777 ш арьс шир, түүхий эд буюу нийт 354371 кг, ширхэг бүтээгдэхүүн

Шилжилт хөдөлгөөн: 6 гэрчилгээгээр 14 толгой адуу шилжилт хөдөлгөөн хийсэн. Үүнээс: Өөр аймаг, сумдаас ирсэн нийт 12 толгой /отор 5, үржилд 7/, өөр аймаг сумд руу явсан мал, амьтан байхгүй, нийт 612 гэрчилгээгээр адуу 117, үхэр 199, хонь644, ямаа 358, гахай 20 толгой буюу нийт 1324 толгой мал, амьтан, 108371 кг мах, махан бүтээгдэхүүн, 242223 кг сүү, сүүн бүтээгдэхүүн,3777 ш арьс шир, түүхий эд буюу нийт 354371 кг, ширхэг бүтээгдэхүүнд мал эмнэлгийн гэрчилгээ олгож, цахим мэдээллийн санд бүртгэгдсэн байна.

Байгаль орчны талаар: 7 сум, 24 аж ахуй нэгжийн Ойн менежментийн төлөвлөгөөг хянан баталгаажуулан, нэгтгэсэн ба сумын Засаг дарга, ИТХ-д ойгоос мод бэлтгэх үйл ажиллагаа, ойн менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах талаар зөвлөмж хүргүүлж, аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 59 иргэн, аж ахуйн нэгж байгууллага нь мод үржүүлгийн газарт мод тарьж ургуулдаг.Ургуулж буй тарьц, суулгацын тоо хэмжээг бодитоор гаргах зорилгоор мод үржүүлгийн газрын тооллого явуулсан. Тооллогоор 8.000.0 сая тарьц, суулгац тоологдлоо.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын талаар: Сүхбаатар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны “2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай” 28 дугаар тогтоолыг батлуулан Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд оруулан баталгаажуулав. Мөн сумдын 2022 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөг баталсан ИТХ-ын тогтоолыг Газрын тухай хууль, Тариалангийн тухай хууль болон хууль тогтоомжоор хориглолт, хамгаалалтын бүс зурвас, газрыг зөрчиж газар олгохоор төлөвлөсөн эсэхэд хяналт хийж зөрчилгүй нэгж талбаруудыг цахим системд бүртгэж баталгаажуулав.

НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Хөдөө аж ахуйн менежмент, экосистемийн тогтвортой байдлыг хангах” төсөлтэй хамтран зохион байгуулж буй Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөн ажлын даалгаврыг сум тус бүрээр боловсруулан батлуулах ажлыг зохион байгуулав.

Аймгуудын газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны дарга нарын удирдах ажилтны зөвлөгөөний хөтөлбөрийн дагуу нийт албан хаагчид цахимаар хөтөлбөрт хамрагдан 2021 оны байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэл, цаашид анхаарч ажиллавал зохих асуудлуудыг хэлэлцэн 2022 оны “Байгууллагын гүйцэтгэлийн

төлөвлөгөө”-г баталгаажуулан ажиллалаа. Тус хурлаар 2021 оны байгууллагын үйл ажиллагааны гүйцэтгэлийг “Маш сайн” гэсэн үзүүлэлтээр дүгнүүлж, “Тусгай байр”-т шалгарлаа.

Зургаа. Сум орон нутгийн ажил үйлчилгээний талаар:

Алтанбулаг сум:

Аймгийн Засаг даргын 2022 оны А/03, сумын Засаг даргын даргын 2022 оны А/01 “Цэргийн бүртгэл зохион байгуулах тухай” тоот захирамжийн дагуу 18-50 насны нэг хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн болон 65 хүртэлх насны бэлтгэл офицеруудыг хамруулж цэргийн бүртгэлийн мэдээ судалгааг маягтын дагуу боловсруулан ажилласан.

Аймгийн Засаг даргын 2022 оны “Монгол Улсын Үндсэн хууль батлагдсаны 30 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх тухай” А/06 тоот захирамжийн дагуу сумын төр, төсвийн байгууллагын дунд Монгол Улсын Үндсэн хуулийг тайлбарлан таниулах, Монголд Улсын Үндсэн хуулийг батлалцсан Сэлэнгэ аймгийн Ардын Их Хурлын депутатуудыг сурталчлан “Үндсэн хуулийг хэн сайн мэдэх вэ?” асуулт хариултын АХА тэмцээн зохион байгуулж, Ерөнхий боловсролын сургуулийн ажилчин Б.Бат-Эрдэнэ, Монгол Улсын Үндсэн Хууль батлагдахад оролцсон депутатуудад зориулан “Талархалын захидал” бичих уралдаанд сумын ЗДТГ-ын нягтлан Р.Насанжаргал нар түрүүлсэн.

Тус сумаас Монгол Улсын Үндсэн хууль батлалцсан Ардын их депутат Санжийн Цэвээндорж агсаны охин Ц.Саранцэцэг ивээн тэтгэж тэмцээнд түрүүлсэн албан хаагчдыг талархал мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан.

Оросын Холбооны улсад малын гоц халдварт “Арьс товруудах” өвчин гарсантай холбогдуулан Сумын Засаг даргын 2022 оны “Нохой устгал зохион байгуулах тухай” А/04 тоот захирамжийн дагуу сумын хэмжээний 53 эзэнгүй нохойг устгасан.

Аймгийн Онцгой комиссын 2022 оны 02 дугаар тогтоолоор халдварын тархалтын түвшин улаан түвшинд хүрсэн учир сумын Засаг даргын 2022 оны А/10 тоот “Ажлын цагийн хуваарийг богиносгох тухай” захирамжаар суманд үйл ажиллагаа явуулж байгаа төр, төсвийн байгууллагуудын ажилтан, албан хаагчдын ажиллах цагийн хуваарийг 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрөөс 02 дугаар сарын 14-ний өдрийг хүртэлх хугацаанд өглөө 10:00-13:00, 14:00-17:00 цаг хүртэлх хугацаагаар цагийн хязгаар тогтоон ажиллаж байна.

Сумын хэмжээнд коронавируст халдварын нийт 211 тохиолдол бүртгэгдэж, аймгийн Нэгдсэн эмнэлэгт 10 иргэнийг хэвтэн эмчлүүлж гэрийн эмчилгээнд 201 иргэнийг хамруулж, эмийн багц тарааж эрүүлжүүлсэн. Аймгийн Онцгой комиссын 2021 оны 32 тогтоолын дагуу эмийн багцын эмийн нэр төрөл, тун хэмжээг нэмэгдүүлэн 8,9,10,11,12-р саруудад гэрээр эмчлэгдсэн иргэдийн судалгааг гарган нөхөн сэргээх 5 төрлийн багцыг бэлтгэж 102 иргэнд олгосон. Мөн түргэвчилсэн оношлуурын шинжилгээнд 314 иргэн, PCR шинжилгээнд 68 иргэнийг хамруулж эрүүл.мн тандалтын программд бүртгэн ажиллаж байна.

Баруунбүрэн сум:

Аймгийн Засаг даргын 2022 оны А/03, сумын Засаг даргын 2022 оны А/01 “Цэргийн бүртгэл зохион байгуулах тухай” захирамжийн дагуу сумын хэмжээнд 18-50 насны нэг, хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн болон 65 хүртэлх насны

бэлтгэл офицеруудыг уламжлалтаар болон цахим үйлчилгээний нэгдсэн портал e-mongolia-аар системээр бүртгэн хамрагдвал зохих иргэдийг 100 хувь хамруулж ажиллалаа.

Сумын хэмжээнд 2021 оны 04 дүгээр сарын 06-ны өдрөөс хойш 2022 оны 01 дүгээр сарын байдлаар коронавируст халдвар “Ковид-19”-ын нийт 305 тохиолдол бүртгэгдэж 2022 он гарснаар 158 иргэнээс түргэвчилсэн оношлуураар шинжилгээ авахад 75 иргэнээс коронавируст халдвар “Ковид-19” илрээд байна. Сайхан сум дахь сум дундын эмнэлэгт зайлшгүй хэвтүүлэх шаардлагатай иргэдийг хэвтэн эмчлүүлж, гэрээр эмчилгээ хийлгэж буй иргэдэд тогтмол хяналт тавин ажиллаж байна. Мөн сумын Эрүүл мэндийн төвөөс коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 2022 оны 1 дүгээр сарын байдлаар I тунд нийт 2137 иргэн хамрагдаж 99 хувьтай, II тунд 2118 иргэн хамрагдаж 99.1 хувьтай, III тунд 1490 иргэн 70.3 хувьтай, IV тунд 239 иргэн хамрагдаж 16 хувьтай байна. Сумын хэмжээнд 28677 м2 талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийлээ.

Сумын Спорт цогцолбороос “Миний дуртай спорт” сэдэвт гар зургийн уралдааныг цахимаар 6-9 нас, 10-13 насны ангилалаар хамгийн их лайк, шэйр цуглуулсан оролцогчийг шалгаруулах журмаар зохион байгуулж 1-3-р байрыг шалгаруулж өргөмжлөл, мөнгөн шагналаар шагналаа.

Иргэдийн чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, спортоор хичээллэх идэвхийг нэмэгдүүлэх зорилгоор Спорт цогцолбороос иргэдийн дунд зохион явуулсан “Волейбол”-ын тэмцээнд эрэгтэй 5 баг, эмэгтэй 6 баг, нийт 11 багийн 80 гаруй тамирчид оролцоноос эрэгтэй эмэгтэй төрөлд 1-3-р байрыг эзлүүлж урамшуулан ажиллалаа.

Тус сумын Орхон бүсийн сум дундын ойн анги нь ойн мэргэжлийн байгууллага “Шинэ Орос хийц” ХХК, “Өндөр заан” ХХК-уудын 3 удаагийн талбай тусгаарлалтын ажлыг хийж гүйцэтгэлээ.

Байгаль орчны хяналтын чиглэлээр Байгаль орчныг хамгаалах тухай багц хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2 удаа, төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг 3 удаа тус тус зохион байгуулж, шалгалтын хүрээнд эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй ойн сангаас зохих дүрэм журмын дагуу мод бэлтгээгүй 2 иргэнд торгуулийн арга хэмжээ авч, 12 м3 хэрэглээний мод, модон материалыг хураан авч, сумын Засаг даргын дэргэдэх орон тооны бус зөвлөлд хүлээлгэн өгч ажиллалаа.

Баянгол сум:

Сумын Засаг даргын 2020 оны “Шуурхай штаб байгуулж ажлын тусгай горимд шилжүүлэх тухай” А/254 дүгээр захирамжийн дагуу Засаг даргын Тамгын газрын байранд шуурхай штабыг байрлуулан 24 цагийн хариуцлагатай жижүүрийг томилж, үүссэн нөхцөл байдалтай холбоотой мэдээ, мэдээллийг аймгийн Онцгой комисс болон холбогдох байгууллагад **70369123** дугаарын утсаар болон цахимаар буюу хаягаар тогтмол хүргүүлэн ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын 2022 оны “Монгол Улсын Үндсэн хууль батлагдсаны 30 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх тухай” А/06 тоот захирамжийн хүрээнд сумын ЗДТГ, Соёлын төв хамтран төр төсвийн байгууллагын нийт 20 албан хаагчдын дунд “Үндсэн хуулийг хэн сайн мэдэх вэ?” асуулт хариултын “АХА” тэмцээнийг

зохион байгуулж 1-р байранд сумын ИТХ-ын ажлын албаны ажилтан Б.Бат-Эрдэнэ, 2-р байранд ЕБС-ийн бага ангийн багш Э.Сувд-Эрдэнэ нар шалгарлаа.

Сумын ЗДТГ-ын цахим хаягаар Үндсэн хууль батлахад оролцсон депутат болон Үндсэн хуулийг сурталчилсан 5 удаагийн мэдээллийг бэлтгэн олон нийтэд сурталчилсан.

Аймгийн Засаг даргын 2022 оны А/03, сумын Засаг даргын 2022 оны А/02 тоот “Цэргийн бүртгэл зохион байгуулах тухай” захирамжийн дагуу цэргийн бэлтгэл алба хаах 18-50 насны 1479 эрэгтэйчүүд бүртгүүлэхээс 1052 үүрэгтэн буюу сумын хэмжээнд 71,1 хувьтай хамрагдсан.

Сар шинийн баярыг тохиолдуулан суманд үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгж байгууллагуудад эмэгтэй 55, эрэгтэй 60-аас дээш настай ахмад настанг Ахмад настны тухай хуулийн дагуу ахмад настанд хүндэтгэл үзүүлэх ажлын хүрээнд 131 аж ахуйн нэгж байгууллагад 581 ахмад настанг хувиарлан албан тоотыг хүргүүллээ.

Азийн хөгжлийн сангаас ковидын улмаас орлого нь буурсан 50 өрхөд хүнсний тусламж үзүүллээ. Мөн ковидыг даван туулах хэрхэн сэргийлэх талаар 2500 гарын авлагыг аж ахуйн нэгж, иргэдэд хүргэлээ.

2022 оны 01 дүгээр сарын байдлаар “Ковид-19” халдвараар 225 иргэн өвчилж гэрийн эмчилгээнд 192 иргэн хяналтад эмчлэгдэж, хяналтаас гарсан 64 иргэн байна. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт 8 иргэн, сумын ЭМТ-ийн ковидын тасагт 25 иргэн тус тус эмчлэгдэж байна. “Ковид-19” халдвараас сэргийлэх дархлаажуулалтад 256 иргэнийг хамруулсан. Халдвар илрүүлэх шинжилгээ 415, ПГУ шинжилгээ 24 тус тус хийлээ.

Аймгийн Онцгой комиссын 2022 оны 06 тоот “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгийн дагуу урьдчилан сэргийлэх, бэлтгэл, бэлэн байдлыг хангах, “Ковид-19” халдварын тархалтыг хязгаарлах зорилгоор сумын Онцгой комиссын хурлаас гарсан шийдвэрийн дагуу төр төсвийн байгууллагууд, худалдаа үйлчилгээ, хоол үйлдвэрлэл, олон нийтийн газрууд ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажлыг тогтмол зохион байгуулан ажиллаж байна. Тус сард сумын хэмжээнд 3500 м2 талбайд ариутгал, халдваргүйтлийг хийсэн.

Улсын аварга шалгаруулах “Жи-Жюүцү” бөхийн тэмцээнд Н.Батболдын багшийн дасгалжуулсан суралцагчид амжилттай оролцож 1 алт, 1 мөнгө, 2 хүрэл медаль хүртлээ.

Сумын ИТХ, СЗДТГ, Спорт цогцолбор, Соёлын төв зэрэг аж ахуйн нэгж байгууллагуудаас ирүүлсэн 6 ажлын байрны захиалгын дагуу ажил идэвхтэй хайгч иргэдээс зуучлах ажлыг зохион байгуулж 6 иргэнийг байнгын ажлын байраар хангасан.

Сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, сумын бэлчээр ашиглалтыг сайжруулах, ногоон байгууламжийг хамгаалах чиглэлээр ажлын хэсгүүд байгуулагдаж “Баянгол сумын Бэлчээр ашиглалтын журам”, “Сумын төвийн А бүсэд бод мал бэлчээхгүй байх журам”-ын төслийг боловсруулан ажиллаж байна.

Цахим системийн гэрчилгээ бичилтэд цаг тухай бүрт хяналт тавин баталгаажилт хийж байгаа 01 дүгээр сарын байдлаар 159 ширхэг буюу бүх төрлийн малын мах 39005 кг, арьс 87 ширхэг, сүү 33868 л, ааруул 100 кг тус тус цахим гэрчилгээ бичигдсэн.

Ерөө сум:

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 97 дугаар тогтоол “Монгол Улсын Үндсэн хууль батлагдсаны 30 жилийн ойг тэмдэглэх тухай”, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2022 оны А/06 тоот “Монгол Улсын Үндсэн хууль батлагдсаны 30 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх тухай” захирамжуудыг үндэслэн дараах ажлуудыг зохион байгуулаа.

1. Монгол Улсын Үндсэн хууль батлалцсан Ардын Их Хурлын депутат, Хөдөлмөрийн баатар Сандагийн Ганболд гуайд хүндэтгэл үзүүлж, түүний товч танилцуулга, ярилцлага болон шторк мэдээллийг цахимаар иргэдэд хүргэж ажилласан.
2. Монгол Улсын Үндсэн хууль батлагдсдад зориулан Ерөнхий боловсролын сургуулийн 10-12 дугаар ангийн сурагчдын дунд “Талархлын захидал”-ын уралдааныг зохион байгуулж шагналт гурван байр эзлүүлэн өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан.

Аймгийн Онцгой комиссын 2022 оны “Коронавируст халдвар /Ковид-19/-ыг эмчлэх Ковидын тасаг байгуулах тухай” 03 тоот тогтоолын дагуу сумын Эрүүл мэндийн төвийн дэргэдэх Ковидын тасгийг нээн ажиллуулж байна. Тус сард “Ковид-19” халдварын 115 тохиолдол бүртгэгдсэнээс эдгэрсэн 32, Ковидын тасагт хэвтэн эмчлүүлж байгаа 39, гэрийн ажиглалт тусгаарлалтад 44 иргэн байна.

Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/737 тоот тушаал, “Гэрийн тусгаарлалтад эмчлэгдэх, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын батлагдсан тохиолдолд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх түр журам”-ын дагуу эмчлүүлэгчдийг хөнгөн, хүндэвтэр, хүнд-ийн зэргээр эрэмбэлэн ангилж, “Ковид-19” халдварт өвчний хөнгөн хэлбэрийг гэрийн тусгаарлалтад үзлэг, эмчилгээ, шинжилгээ болон эмийн багцад хамруулан эрүүл мэндийн зөвлөгөө мэдээлэл өгч ажиллаж байна.

Коронавируст халдварын эсрэг дархлааны түвшинг нэмэгдүүлэх зорилгоор сайн дурын үндсэн дээр 712 иргэнийг IV тунгийн дархлаажуулалтад хамруулсан.

Иргэдийн хууль бус мод бэлтгэлийн чиглэлээр төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус 2 удаагийн эргүүл, хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж ажилласан бөгөөд зөрчил дутагдал илрээгүй байна.

“Түмэн сарлагтан” ХХК, “Зулзаган төгөл” ХХК, “Батхаан майнинг” ХХК зэрэг гурван нөхөрлөлийн мод бэлтгэлийн гүйцэтгэлд хяналт тавьж хэмжилт хийсэн.

01 дүгээр сард 1,2 дугаар багийн 29 иргэнд 116 м3 “Түлээний эрхийн бичиг” -ийг олгоод байна.

Аймгийн мэргэжлийн хяналтын газрын Улсын ахлах байцаагчийн 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 03, 04, 05 тоот зөвлөмжүүдийг Худалдаа үйлчилгээний зургаан аж ахуйн нэгж, гурван цайны газарт хүргэж ажиллалаа. Мөн аж ахуйн нэгжийн ариутгал халдваргүйжүүлэлт болон иргэдийн халдвар хамгааллын дэглэмд хяналт тавих заавар зөвлөгөөг гурван удаа хүргэсэн.

Төсвийн хөрөнгө оруулалтаар:

- Шинээр гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар олгосон газрын цахилгааны зураг төсөв хийлгэх 20000,0 мянган төгрөгийн өртөгтэй ажлын дэвсгэр зураг хийлгэхээр “Ариун Мөнхийн гэрэл” ХХК-тай гэрээ байгуулсан.

- Бугант тосгоны сургуулийн хоолны газарт агааржуулалтын хоолой хийх засварлах” ажилд 5306507 регистрийн дугаартай “Товруу сүмбэр” ХХК 15710,9 мянган төгрөгөөр шалгарч гэрээ байгуулсан.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар:

- Ерөө Соёлын төвд Лед дэлгэц худалдан авах ажлыг tender.gov.mn хаягаар зарласан, шалгаруулалтын шатандаа явж байна.

ДЗМОУБ-аас “Өсвөрийн аврагч” клубт 5 төрлийн 2141046 төгрөгийн сургалтын хэрэгслийг буцалтгүй тусламжаар хүлээлгэн өгсөн.

Жавхлант сум:

Сумын Засаг даргын 2022 оны А/09 тоот захирамжаар төсвийн сар, улирлын хуваарь батлагдлаа. Үүнд:

- Сумын төсвийн орлого-1,108,648,200 төгрөг
- Сумын төсвийн байгууллагуудын зарлага-1,344,004,100 төгрөг

Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд 2022 онд орон нутгийн төсвөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөөг байршуулсан. Үүнд:

№	Худалдан авах, бараа ажил үйлчилгээ	Төсөвт өртөг /мян. төгрөг/
1	Зураг төсөв хийх зардал	17453,2
2	Улсын баяр наадмын зардал	5000,0
3	Ногоон байгууламжийн хашааг нэмэгдүүлэх	20000,0
4	Хогийн цэгийг хашаажуулах	2000,0
5	Сумын төвийн гэрэлтүүлэг нэмэгдүүлэх	75000,0
	Нийт	137453,2

Аймгийн Засаг даргын 2022 оны А/03, сумын Засаг даргын 2022 оны А/05 тоот “Цэргийн бүртгэл зохион байгуулах тухай” захирамжийн хүрээнд 01 дүгээр сарын 07-21-ний өдрүүдэд сумын хэмжээнд цэргийн бүртгэлийг зохион байгуулж 18-50 насны нэг, хоёрдугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн болон 65 хүртэлх насны бэлтгэл офицеруудыг хамруулан ажиллалаа. Нийт 518 иргэнээс 157 иргэн бүртгүүлж, хамрагдалт 30.3 хувьтай байна.

2022 оны 01 дүгээр 01-ний өдрөөс эхлэн Коронавируст халдвар дахин бүртгэгдэж, түргэвчилсэн шинжилгээгээр 56, ПСР1, нийт 57 тохиолдол бүртгэгдсэнээс хүүхэд 13, насанд хүрэгчид 44 хүн байна. Эдгэрч хяналтаас гарсан 26, гэрийн эмчилгээнд 31 хүн хянагдаж байна. Коронавирусын эсрэг дархлаажуулалтын III тунд 21, IV тунд 89 иргэн хамрагдсан.

Ариутгал халдваргүйтгэлийг төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгжүүдийн 6753 м2 талбайд хийсэн.

“Ковид-19”, малын шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх, хүүхдэд зориулсан мэдээ, мэдээллийг сумын цахим хаягуудаар дамжуулан иргэд, малчдад нийт 17 удаагийн давтамжтайгаар хүргэн ажилласан.

ДЗМОУБ-ын Сэлэнгэ нутгийн хөтөлбөрт сумын Ерөнхий боловсролын сургуулиас хүргүүлсэн “Бидний орчин” төсөл шалгарч эхний ээлжид 60 ширхэг хүүхдийн хөнжил сургуулийн дотуур байрны сурагчдад олгогдлоо. Мөн тус

байгууллагаас “Би бол сайн аав” сургалтыг цахимаар зохион байгуулж, 35 аав хамрагдсан.

Сумын Засаг даргын 2022 оны “Угийн бичиг хөтлөх ажлыг эрчимжүүлэх ажлын хэсэг байгуулах тухай” А/11 тоот захирамжийн дагуу хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Сар шинийн баярыг угтаж “Мэндийн ерөөлтэй сар шинэ” ардын дууны зохиомжит онлайн мэндчилгээ тоглолт бэлтгэн иргэд олон нийтэд цахимаар цуврал хэлбэрээр хүргэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Үндсэн хууль батлагдсан өдрийг угтан Соёлын төвөөс төр төсвийн байгууллагын албан хаагчид иргэдийн дунд Эссэ бичих, V-XII ангийн сурагчдын дунд гар зургийн цахим зохион байгууллаа.

Аймгийн ХХААГ-аас зохион байгуулж буй “Нэг суурин нэг бахархал” аянд сумын өв тээгч сургагч багш Г.Цэвгээгийн ноосон эдлэлийн гар урлалын бүтээл оролцсон.

2021 оны ноосны урамшуулалд хамрагдах 99 малчны материалыг аймгийн ХХААГ-т хүргүүлэн ажиллалаа.

Зүүнбүрэн сум:

Аймгийн Засаг даргын 2022 оны “Монгол Улсын Үндсэн хууль батлагдсаны 30 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх тухай” А/06 тоот захирамжийн хэрэгжилтийг ханган ажиллаж Зүүнбүрэн сумаас сонгогдож Үндсэн хууль батлалцсан Ардын их хурлын депутат М.Доржсүрэн агсны талаарх мэдээлэл болон Үндсэн Хуулийн нэмэлт өөрчлөлтийн талаарх мэдээллийн радио үзэлээр дамжуулан сумын нийт иргэдэд сурталчиллаа.

Ардын их хурлын депутат М.Доржсүрэн агсны гэр бүл үр хүүхдүүдэд цахим хэлбэрээр дамжуулан сумын Засаг даргаас мэндчилгээ дэвшүүлж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, сумын Засаг даргын Тамгын газраас хүндэтгэл үзүүлээ.

Сумын Онцгой комиссын хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулж “Урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх тухай” 01 тоот тогтоол гаргалаа. Сумын Онцгой комисс, Шуурхай штабаас коронавируст халдварын цаг үеийн нөхцөл байдлын талаарх мэдээлэл хийж, иргэдэд амны хаалтаа тогтмол зүүж халдвар хамгааллын дэглэмээ баримтлах зөвлөмж бүхий 2 шторк бэлдэн цахим орчноор дамжуулан сурталчиллаа.

Сумын Засаг даргын Зөвлөлийн хурал хуралдаж “Аймгийн аварга малчин”, “Аймгийн аварга механикжуулагч”-д тус бүр 1 иргэнийг шалгаруулан материалыг холбогдох дээд шатны байгууллагад хүргүүллээ. “Сумын аварга малчин”-аар 3, “Сумын аварга ногоочин”-оор 1 иргэнийг шалгарууллаа.

Сар шинийн баярыг тохиолдуулан УИХ-ын гишүүн Д.Өнөрболор 75-аас дээш насны 45 ахмад настанд гарын бэлэг, “Улсын аварга малчин” Т.Бат-Орших 3 өндөр настанд тус бүр 1 хонь, “Улаан загалмайн хороо”-оос тус бүр 10 кг будаа, Жаргалант 1 дүгээр багийн иргэн Н.Мөнхбаяр 2 өрхөд тус бүр 1 хонины гулууз мах хандивлалаа.

Мөн Катарын “Улаан хавирган сар” нийгэмлэгийн хамтарсан “Дулаан өвөл” төслийн хүрээнд Зүүнбүрэн сумын 1 иргэнд гэрийн дулаалга эсгий хөнжил гудас тус бүр 2 ширхэгийг хүлээлгэн өглөө.

Аймгийн “Оны онцлох хүүхэд 2021” арга хэмжээний “Эх орны түүх, соёл өв уламжлал” төрөлд 10а ангийн сурагч Ц.Чингүн шалгарлаа.

“Төгсөгчийн яриа” цуврал ZOOM уулзалтыг 4 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 60 сурагч хамрагдлаа.

Мандал сум:

Сумын хэмжээнд Коронавирус “Ковид-19” цар тахлын дэгдэлт нэмэгдэж нөхцөл байдал хүндэрсэн тул сумын Онцгой комисс шуурхай хуралдаан зохион байгуулж “Коронавирус Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх тухай” 01 тоот тогтоолыг гарган хэрэгжүүлэн ажиллаж байна.

Сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 135 ААНБ-ын ариутгал халдваргүйтгэлд хяналт тавих, заавар зөвлөмж өгөх зорилгоор сумын ЗДТГ, Онцгой байдлын хэлтэс, Цагдаагийн хэлтсийн албан хаагчдаас бүрдсэн ажлын хэсгийг томилон халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, халдвар хамгаалалтын дэглэм баримталж байгаа байдалд үзлэг хийлээ.

Үндсэн хууль батлагдсаны 30 жилийн ойг тохиолдуулан тус сумаас Ардын Их хурлын депутатаар сонгогдож Үндсэн хууль батлалцахад оролцож байсан Д.Тангад, Ж.Жавзандорж, Д.Батбаяр нарын намтраар мэдээлэл бэлтгэн ард иргэдэд сурталчиллаа.

2022 оны 01 дүгээр сарын 01-нээс хэрэгжиж эхэлж буй Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон Төрийн албаны тухай хуулиар сумын Засаг даргын Тамгын газрын 63 албан хаагчдад сургалт зохион байгууллаа.

Сумын удирдах ажилтны 2022 оны анх дугаар зөвлөгөөнийг зохион байгуулан 34 удирдлагыг хамруулан Сумын эдийн засгийн үзүүлэлт, Эрүүл мэндийн өнөөгийн нөхцөл, Төсвийн талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, Төсвийн шууд захирагч нарын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, 2022 оны төлөвлөлт, Хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах талаар сургалт мэдээлэл өглөө.

Орхон сум:

Аймгийн Засаг даргын 2022 оны А/03 тоот “Цэргийн бүртгэл зохион байгуулах тухай” захирамжийн дагуу сумын Засаг даргын 2022 оны А/03 тоот захирамжаар цэргийн тоо бүртгэлийн ажлыг зохион байгуулж 80 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна.

Мал амьтны гоц халдварт шүлхий /А01/ өвчний тохиолдол 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрөөс хойш бүртгэгдээгүй тул аймгийн Онцгой комисст хүсэлт илгээсний дагуу аймгийн Засаг даргын 2022 оны А/04 тоот “Хорио цээрийн дэглэмийг цуцалж, хязгаарлалтын дэглэмд шилжүүлэх тухай” захирамжийн хүрээнд сумын Засаг даргын 2022 оны А/01 тоот захирамжаар хязгаарлалтын дэглэмд шилжүүлсэн. Мөн хязгаарлалтын дэглэмээс хойш 14 хоногийн хугацаанд дахин шинэ голомт үүсээгүй тул сумын Засаг даргын 2022 оны А/06 тоот захирамжаар хязгаарлалтын дэглэмийг хэвийн горимд шилжүүллээ.

(Ковид-19) халдварын эсрэг дархлаажуулалтад 01 дүгээр сарын байдлаар сайн дураар I тун 7, II тун 4, III тун 25, IV тунд 69 иргэн хамрагдаад байна.

Цаг үеийн болоод коронавирусын халдварын талаарх зөвлөмж, анхааруулга болон (Ковид-19) халдварын эсрэг дархлаажуулалтад идэвхтэй хамрагдахыг уриалсан уриалга, нөлөөллийн ажлыг зохион байгуулж, цахим орчинд вакцины ач холбогдлыг сурталчлан таниулах зорилгоор мэдээ мэдээлэл, шторк, сурталчилгааг “Сэлэнгэ Орхон сум Здтг”, “Сэлэнгэ аймгийн Орхон сум”

“Нарт Орхоны хүүхдүүд”, “SelengeOrhonEmt” зэрэг фэйсбүүк хаягуудад байршуулан 65 удаагийн мэдээ мэдээллийг хүргэж 454 хүний хандалтыг авсан байна.


Сумын архины хамааралтай 1 гэр бүлийн 2 иргэний эмчилгээний зардлыг аймгийн ГБХЗХГ-аас “Хариу үйлчилгээний тусламж” 2.400.0 төгрөгийг шийдвэрлэж “Гоё амьдрал гэгээ” ХХК-тай гэрээ байгуулан гипноз код эмчилгээнд хамрууллаа.

Сумын ИТХ-ын 2021 оны 25 дугаар тогтоолоор 2022 оны “Газар зохион байгуулалтын төлөвлөгөө”-г батлуулан ажиллалаа.

Сэлэнгэ аймгийн Орхонтуул сумын нутаг дэвсгэрт хууль бусаар ашигт малтмал ашигласан 1 иргэнд Зөрчлийн тухай хуулийн дагуу 1.000.0 төгрөгийн торгуулийн арга хэмжээ тооцсон.

Мал, амьтны гоц халдварт шүлхий /A01/ өвчин гарсантай холбогдуулан голомтын бүсийн 20 өрхийн 65 толгой үхрийн сэг зэмийг устгах ажлыг зохион байгуулж, устгалын цэгийг халдваргүйжүүлэхэд хяналт тавин ажиллалаа.

2021 оны жилийн эцсийн мал, тэжээвэр амьтдын тооллогын дүнгээр адуу 6488, үхэр 14561, хонь 48947, ямаа 40225 бүгд 110221 толгой мал тоологдлоо. Сумын нийт малын тоо толгой өмнөх оноос 1,5 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Ямаан сүргийн тоо толгой өмнөх оноос 11,1 хувиар буурсан байна.



Бэлэндалай багийн малчин Д.Өлзийсайханыг “Аймгийн аварга малчин”, аймгийн аварга малчин Б.Буянбатыг “Улсын аварга фермер”, Улсын аварга малчин Л.Баянмөнхийг “Улсын Хошой аварга малчин өрх”-д тус тус тодорхойлж холбогдох баримт материалыг бүрдүүлж аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газарт хүргүүлсэн.

Орхонтуул сум:

Монгол Улсын Үндсэн хуулийн 30 жилийн ойн хүрээнд сумын “Хүүхэд хөгжлийн төв”-тэй хамтран халдвар хамгааллын дэглэмийг баримтлан ахлах, дунд ангийн сурагчдад хуулийн сургалт хийж “Элсэн цаг” танин мэдэхүйн тэмцээн зохион байгуулан ажиллалаа. Мөн цахимаар Монгол Улсын Үндсэн хуулийн талаарх сургалт, мэдээ мэдээллийг иргэдэд хүргэн ажиллалаа.

Коронавируст халдварын тохиолдол эрчимтэй нэмэгдэж эрсдэл нэмэгдэж байгаатай холбогдуулан санамж зөвлөмжийг иргэдэд тогтмол хүргэн вакцины IV тунд идэвхтэй хамрагдуулах ажлыг Эрүүл мэндийн төвүүдтэй хамтран зохион байгуулж байна.

Уралдаанч хүүхдийн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор сумын засаг даргын 2022 оны 01 сарын 13-ны өдрийн А/03 тоот захирамж гарган уяачдын холбоо иргэдэд хүргэсэн. 2022 онд хийгдэх ажлын төлөвлөгөө болон судалгаануудыг шинэчлэн гаргаж мэдээллийн санг шинэчилсэн. Хамтарсан багийн “Орхонтуул сум хамтарсан баг” фэйсбүүк хуудас нээн ажиллуулж байна.

Аймгийн аварга малчин өрхийн болзол хангасан 3 малчны холбогдох материалыг бүрдүүлж аймгийн ХХАА-н газарт хүргүүлсэн. Мөн сумын сайн малчин өрхийн болзол хангасан 9 малчин, 1 фермерч, сумын алдарт уяачийн болзол хангасан 2 уяачийн холбогдох материалыг бүрдүүлж сумын Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлсэн.

Газар тариалангийн салбарт өндөр амжилт гаргасан 3 иргэнийг аймгийн аварга тариаланчаар, 1 аж ахуй нэгжийг Аймгийн аварга тариаланч хамт олноор, Улсын аварга тариаланч хамт олноор 1 аж ахуйн нэгжийн холбогдох материалыг бүрдүүлж дээд шатны байгууллагад хүргүүлэн ажиллалаа.

Сайхан сум:

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 97 дугаар тогтоолын дагуу шинэ Үндсэн хууль батлагдан гарсны 30 жилийн ойг тохиолдуулан 01 дүгээр сарын 11-18-ыг Үндсэн хуулийг тайлбарлан таниулах 7 хоног болгон зарлаж сумын Засаг дарга цахим хаягаар мэндчилгээ дэвшүүлж сумын төр, төсвийн байгууллагын 105 албан хаагчид Үндсэн хуулийн нэмэлт өөрлөлтийг танилцуулан ажиллалаа. Монгол Улсын Үндсэн хуулийн богино хэмжээний мэдээлэл бэлтгэн сургуулийн 35 бүлгийн 1069 сурагчдад болон тэдний эцэг эх асран хамгаалагчдад хүргэн ажиллалаа.

Зам тээврийн осол гэмтлээс урьдчилан сэргийлэх зорилгоор Сайхан сумын “Эвт нөхөд” ХХК, “Хаш хүлэг” ХХК-ий жолооч нар болон Сумын “Ахмадын холбоо”-ны 19 иргэнд Сайхан сум дахь сум дундын Цагдаагийн хэлтэстэй хамтран сургалт зохион байгуулан ажиллалаа.

2022 оны 01 дүгээр сарын байдлаар Сум дундын Цагдаагийн хэлтэстэй хамтран байгаль орчны чиглэлээр хяналт шалгалтын хүрээнд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг 1 удаа, иргэний гомдол мэдээллийн дагуу хяналт шалгалтыг 3 удаа тус тус зохион байгуулж өмчлөлийн газар давхцсан 2 иргэний гомдлыг шалган шийдвэрлэлээ.

Засгийн газрын 148 тоот тогтоолын дагуу Хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчны аюулгүй байдлыг хангах зорилгоор агаар, ус хөрсний чанарын техникийн зохицуулалтыг 2022 оны 01-р сараас заавал дагаж мөрдүүлэх тухай ААНБ-н дарга эрхлэгч нарт албан бичиг хүргүүлж хуулийг сурталчилж ажиллалаа.

Төмс, хүнсний ногоо тариаланч 1 иргэн, байгалийн хадлан бэлтгэсэн 2 иргэнд ургамал, түүний гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний гарал, үүслийн гэрчилгээг олгон ажиллаж байна. Мөн FSI хүнсний аюулгүй байдлын удирдлагын системд 1 иргэнийг бүртгэж ногоочны тамга захиалав.

“Нэг суурин-Нэг бахархал” аяны хүрээнд сумын брэнд бүтээгдэхүүнийг шалгаруулж “Сүүн зам” ХХК, “Хөтөл жимсгэнэ”, “Oyu candle”, “Хөтөл кимчи” тус тус шалгарлаа.

Эрүүл мэнлийн төвийн Ковидын тасагт 25 иргэн хэвтэн эмчлүүлж байна. Үүнээс Сайхан 13, Номгон 2, Баруунбүрэн 8, Сант 1, Орхон 1 иргэн тус тус эмчлэгдэж байна. Гэрийн тусгаарлалтад 184 иргэн эмчилгээнд байна. Сумын хэмжээнд дархлаажуулалтын I тунд 4377 иргэн хамрагдаж 100 хувь, II тунд 4234

иргэн хамрагдаж 97 хувь, III тунд 2551 иргэн хамрагдаж 60.2 хувь, IV тунд 162 иргэн хамрагдаж 6.3 хувьтай байна.

Сант сум:

Сумын хэмжээнд нэгдүгээр сард “Ковид-19” халдварын батлагдсан тохиолдол нийт 94 бүртгэгдсэнээс хүүхэд 26 байна. Үүнээс эдгэрсэн том хүн 28, хүүхэд 14, эмчлэгдэж байгаа нийт 52 үүнээс хүүхэд 12 байна. Нийт 34 өрхийн 92 хүн гэрийн тусгаарлалтад байна.

Эрүүл мэндийн сайдын 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/01 тоот тушаалын дагуу “Ковид-19” халдварын эсрэг IV тунгийн дархлаажуулалтад 18-аас дээш насны 182 иргэн хамрагдаад байна.

Сумын Засаг даргын 2022 оны А/02 дугаар захирамжаар хорио цээрийн дэглэмийг цуцалж хязгаарлалтын дэглэмд шилжүүлсэн. Дэглэм цуцлагдсанаас хойш адуу 5, үхэр 42, хонь 30, ямаа 25 нийт 102 малын 7,2 тн мах зах зээлд борлуулагдаад байна.

“Монгол мал” үндэсний хөтөлбөр, аймаг, сумын Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан малын үүлдэр угсааг сайжруулж, малчдын орлогыг нэмэгдүүлэх зорилтыг хангах ажлын хүрээнд аймгийн хөрөнгө оруулалт 40,0 сая төгрөгийн санхүүжилтээр Казакын цагаан толгойт үүлдрийн хээлтүүлэгчээр хангах ажил зарлагдаж гүйцэтгэгчээр Дархан-Уул аймгийн “Юниверсал Нетворк” ХХК шалгарч өсвөр 14 бухыг нийлүүллээ. Хээлтүүлэгчийг хүлээн авч үхрийн чанар, зуслангийн байршил, ашиглах хүртээмжийг харгалзан 14 малчинд гэрээгээр хариуцуулж хүлээлгэж өгөх ажлыг зохион байгууллаа.

Малчдад мэдээ мэдээллийг түгээх, мэдээлэл солилцох, бодлогын баримт бичиг, шийдвэрт малчдын саналыг тусгах, оролцоог хангах, аливаа ажил, арга хэмжээнд малчдыг зохион байгуулалттайгаар оролцуулах зорилгоор “Малчдын Аравт” сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, сумын ИТХ-ын ХАА-н бодлогын хороо, малчдын төлөөлөл, багийн Засаг дарга нар, мал эмнэлэгийн тасгийн төлөөлөл 12 хүн хамрагдлаа.

Суманд зөгийн аж ахуй эрхлэгчдийг бодлогоор дэмжих ажлын хүрээнд зөгийн аж ахуй эрхлэх боломж, ач холбогдол, үр ашгийг сурталчлан таниулах зорилгоор хэлэлцүүлэг, сургалт мэдээллийн ажлыг зохион байгуулж 11иргэнийг хамрууллаа. Хэлэлцүүлгийн үр дүнд “Сантын зөгийчид” фэйсбүүк хуудас нээж, хоршоо байгуулах шийдвэрийг гаргалаа. ДЗМОУБ-д хандсанаар зөгийн аж ахуй эрхлэгч иргэд, хоршоонд дэмжлэг үзүүлэхээр боллоо.

ДЗМОУБ “Сэлэнгэ нутгийнхөтөлбөр”-өөс “Ковид-19” цар тахлын үед дэмжлэг үзүүлж “Төгсөлтийн аргачлал” арга хэмжээнд хамрагдаж байгаа сумын 20 өрх тус бүрт 100.000 төгрөгийн хүнсний багц, ундны усны 50 литрийн сав зэрэг нийт 3.000.0 төгрөгийн тусламжийг олголоо. Мөн 783.0 төгрөгийн өртөгтэй замын гарц, тэмдэг, тэмдэглэгээг Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт хүлээлгэн өглөө.

Хүүхдийг гэмт хэрэг, зөрчил, ахуйн осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн эрхийг хангах, хамгаалах зорилгоор судалгаа хийж эрсдэлт нөхцөлд амьдарч буй 25 хүүхдийг сумын хамтарсан багийн хяналтад авч ЕБС-иас гэрийн эргэлтийг тогтмол хийж байна.

Сумын хэмжээнд бүтэн өнчин 3 хүүхэд байгаа бөгөөд хүүхдүүдийн нөхцөл байдлыг амьдарч байгаа газарт нь очиж үнэлгээ хийн “КОВОТООЛБОХ” цахим программд бүртгэлээ.Тухайн хүүхдүүдийн амьдарч байгаа орчин нөхцөлтэй

танилцаж асран хамгаалагч нарт Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулийг сурталчиллаа.

Аймгийн Засаг даргын 2022 оны “Монгол Улсын Үндсэн хууль батлагдсаны 30 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх тухай” А/06 дугаар захирамжийн дагуу “Үндсэн хуулийн тухай ойлголт, Үндсэн хууль бүтсэн түүхэн замнал”, сум орон нутагт ажиллаж амьдарч байсан АИХ-ын 3 депутатуудын намтар түүхийг өгүүлсэн мэдээллийг цахимаар сурталчиллаа. Үндсэн хуулийг дээдлэх, судлах, сахин биелүүлэх, залуу үеийнхэнд эх оронч үзлийг төлөвшүүлэх зорилгоор 18-34 хүртэлх насны залуучуудын дунд “Үндсэн хууль дахь иргэн миний үүрэг” сэдэвт Эссэ бичлэгийн уралдааныг зарлаад байна.

Гэр бүлийн харилцаа хүүхдийн хөгжил төлөвшилд аавуудын оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр зохион байгуулсан “АФА Академи”-ийн тэргүүнлектор Ш.Амартүвшингийн “Сайнаав” эрчүүдэд зориулсан сургалтанд 23 иргэнийг хамрууллаа.

ДЗМОУБ-аас “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга” үндэсний сургагч багшаар 1 иргэнийг, “Гэр бүлийн баяр хөөр” сургагчаар ЕБС-ийн 2 багшийг бэлтгэж “Гэр бүлийн баяр хөөр” сургалтыг зохион байгуулж зорилтот бүлгийн 14 иргэн хамрагдлаа.

Сүхбаатар сум:

Монгол Улсын Үндсэн хууль батлагдсаны 29 жилийн ойн хүрээнд 1 сарын хугацаанд Сүхбаатар сумын Засаг даргын Тамгын газар нь албан хаагчдад болон иргэдэд сумын цахим хаягаар Монгол Улсын Үндсэн хуулийг сурталчиллаа.

Аймгийн Засаг даргын удирдамжийн дагуу тус Тамгын газрын ажлын хэсэг сумын Засаг даргын Тамгын газрын бодлогын баримт бичиг, архив бичиг хэрэг, хөрөнгө оруулалтын ажил болон өдөр тутмын үйл ажиллагаатай танилцан заавар зөвлөгөө өгч зөвлөн туслах үйлчилгээг үзүүллээ.

Сумын хамтарсан багийн хурлаас гарсан шийдвэрийн дагуу 3-р багийн хараа хяналтгүй архины хамааралтай өрхийн 3 хүүхдэд эмнэлгийн болон хүнсний тусламж үзүүллээ.

Сүхбаатар сумын тандалтын баг долоо хоног бүрийн Даваа, Лхагва, Баасан гаригуудад ПГУ шинжилгээг авч байна. Халдварын тохиолдол эрс нэмэгдэж байгаатай холбоотойгоор өдөрт 350-400 иргэнээс шинжилгээ авч байна.

01 дүгээр сарын байдлаар гэрийн тусгаарлалтад том хүн 239, хүүхэд 744, нийт 983 хүн байна.

“Тэрбум мод” аяны хүрээнд Сэлэнгэ аймаг нийлүүлэгч аймаг болох зорилт тавьсны хүрээнд Сүхбаатар суманд мод үржүүлгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэн, аж ахуйн нэгж байгууллагын үрийн нөөц болон тарьц суулгацын тооллого зохион байгуулж өнөөдрийн байдлаар 50000 суулгац, 20 кг үр нөөцөд байна.

Австри Улсын Засгийн газрын хөрөнгөөр “Дэд бүтэц төсөл-ийн хүрээнд 800 ширхэг гэрэлтүүлэг хийгдэж улсын комисс ажилласан боловч Мэргэжлийн хяналтын газраас стандартын дагуу хийгдээгүй гэсэн шалтгааны дагуу ажлын хэсэг гарган хэмжилт хийхээр төлөвлөөд байна.

2022 онд Улс, аймаг, орон нутгийн хөрөнгө, орон нутгийн хөрөнгөөр дараах ажлууд хийгдэхээр зураг төсөв, гэрээ байгуулан ажиллаж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар		
№	Төсөл арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Төсөвт өртөг
1	Хүүхдийн хөгжлийн усан бассейн, сургалтын төвийн барилга /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	3,500,000.0
2	Цэцэрлэгийн барилга, 200 ор /Сэлэнгэ, Сүхбаатар сум, 4 дүгээр баг/	4,154,000.0
3	Ногоон байгууламжийн усалгааны систем /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	250,000.0
4	Нийтийн эзэмшлийн талбайн тохижилт /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	1,400,000.0
5	Хилийн 0243-р ангийн цэргийн байр	2.302.100.0
6	Цэвэрлэх байгууламжийн их засвар, шинэчлэл	500.000.0
7	Аймгийн хүнс хөдөө аж ахуйн лабораторийн барилга	2.000.000.0
8	Дулааны станцын зуухны шинэчлэл	1.600.000.0
9	Эрүүл мэндийн төвийн барилга	1.800.000.0
10	Нэгдсэн эмнэлгийн барилга, дотор сантехникийн засвар	2.735.000.0
11	Шүүхийн шинжилгээний албаны лабораторийн барилга	200.000.0
Аймгийн хөрөнгө оруулалт		
№	Төсөл арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Төсөвт өртөг
1	Цэцэрлэгийн барилга, 200 ор /Сэлэнгэ, Сүхбаатар сум, 4 дүгээр баг/	300,000.00
2	Бохирын шугам татах /Сүхбаатар сум, Баянхан 4-р баг/	110,000.00
3	Балгас барилга буулгах /Сүхбаатар сум, Ганзам 7-р баг/	60,000.00
4	Цахилгаан шугамын хүчдэл нэмэгдүүлэх /Сүхбаатар сум, Боргүвээ 5-р баг/	495,000.00
5	Цэвэр усны шугам татах /Сүхбаатар сум, Хонгорморьт 1-р баг/	495,000.00
6	Цементэн хучилттай зам тавих /Сүхбаатар сум, Буурхээр 8-р баг/	100,000.00
7	Дулааны шугам татах /Сүхбаатар сум, Буурхээр 8-р баг/	30,000.00
8	"Алтан намрын шим" худалдаа үйлчилгээний газарт гүний худаг гаргах /Сүхбаатар сум, Боргүвээ 5-р баг/	200,000.00
9	"Алтан намрын шим" худалдаа үйлчилгээний газрын зогсоол байгуулах /Сүхбаатар сум, Боргүвээ 5-р баг/	150,000.00
10	4,5,12-р байрны дээврийн засварын ажил /Сүхбаатар сум Орхон 6-р баг/	50,000.00
11	16-н айлын орон сууцны засвар /Сүхбаатар сум Ганзам 7-р баг/	60,000.00
11	6-р сургуулийн сантехник, худгийн засвар /Сүхбаатар сум Боргүвээ 5-р баг/	140,000.00
12	5-р сургуулийн их засвар, гадна биеийн тамирын талбайн засвар /Сүхбаатар сум Хонгорморьт 1-р баг/	50,000.00
Замын сангийн хөрөнгөөр		
№	Төсөл арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Төсөвт өртөг
1	Сүхбаатар сумын гэрлэн дохио	335,000.00
2	Сүхбаатар сумын зам засвар, тэмдэг тэмдэглэгээ,	50,000.00

	замын гэрэлтүүлэг	
--	-------------------	--

Орон нутгийн хөрөнгөөр

№	Төсөл арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Төсөвт өртөг
1	1-р багт хашаа	20.000.00
2	6-р багт талбай шинээр байгуулах	45.000.00
3	Үндэсний спортын тоног төхөөрөмж	5.000.00
4	Сумын ЗДТГ-т машин худалдан авах	25.000.00
5	Нийтийн тээврийн үйлчилгээний бага оврын автобус худалдан авах	19.500.00
6	5-р багийн Бойны тохойн гэрэлтүүлэг	20.000.00
7	Иргэний танхимын засвар	20.000.00
8	4-р баг 16 айлын орон сууцны гадна засвар	30.069.90

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр

№	Төсөл арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Төсөвт өртөг
1	Алслагдсан багуудад хог тээврийн авто машин авах 1.3.4.5.8-р багт	125.000.00
2	Ган замын 7-р багт нийтийн эзэмшлийн жишиг гудамж талбай байгуулах	400.000.00
3	3-р багт тоглоомын талбай	50.000.00
4	8-р багт тоглоомын талбай	50.000.00
5	1-8-р багийн гэрэлтүүлгийн засвар	17.896.00

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө 125.0 сая төгрөгөөр 5 машин авах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендерийг зарлаад байна.

Түшиг сум:

2022 оны 01 дүгээр сарын байдлаар “Ковид-19” халдварын 108 тохиолдол бүртгэгдсэнээс дээд шатны ковидын халдварыг эмчлэх тасагт 2, гэрээр тусгаарлан эмчилсэн 36, гэрээр тусгаарлан эмчлэгдэж байгаа 72 иргэн байна. “Ковид-19” халдвараас урьдчилсэн сэргийлэх IV тунд 40 хүн тун дархлаажуулаад байна.

УИХ-ын гишүүн Ж.Эрдэнэбатын дэмжлэгтэйгээр Биеийн тамирын багш Э.Батцоож нь “Хүүхдийн Эрүүл мэнд-Спорт”-ыг дэмжих төсөл бичиж 10.000.0 төгрөгийн санхүүжилтийг авч заалны засвар, сургалтын хэрэглэгдэхүүнд зарцуулсан.

“Улаан овоо”-ийн нүүрсний уурхайгаас иргэдэд хөнгөлөлттэй үнэ /1тн 20,000 төгрөг/-ээр 1150 тн нүүрсийг 575 өрхөд олгосон. Ахмад настай болон зорилтот бүлгийн 6 айл өрхөд 30 м3 түлээний модыг үнэ төлбөргүйгээр буулгаж өгсөн.

Мөн УБТЗ-ын харьяа мод боловсруулах үйлдвэр 30 айл өрхөд 300 м3 хэрэглээний модыг хөнгөлөлттэй үнээр худалдан борлуулах ажлыг зохион байгуулсан.

Сумын 70-аас дээш настай 48 ахмад настанд Засаг дарга сар шинийн баярыг угтан хүндэтгэл үзүүлсэн.

Сумын Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг 1, 2 дугаар багийн 38 малчин айл өрхийн өвөлжилтийн байдалтай танилцаж, саналыг сонсож ажиллалаа.

Хушаат сум:


Шинэ Үндсэн хууль батлагдсаны 30 жилийн ойг тохиолдуулан Үндсэн хуулийн видео хичээлийг сумын ЗДТГ-ын цахим хуудаст нийтэлж 573 иргэн үзэж бусад байгууллага, иргэд 7 удаа хуваалцан иргэдэд түгээж сурталчиллаа.

Шинэ Үндсэн хуулийг батлалцсан, АИХ-ын депутат Х.Намсрайжав агсны ажил амьдралын талаар зурган болон видео дурсамжийг 3 удаа нийтэлж хүүхэд залуучуудад Үндсэн хуулийн талаар ойлголт, мөн ахмад төрийн албан хаагч Х. Намсрайжав агснаар бахархан үлгэр дуурайлал болгох хандлагыг төлөвшүүлэхийг зорин ажиллалаа. Шинэ Үндсэн хуулийн 30 жилийн ойд зориулан " Үндсэн хууль-хүний эрх, эрх чөлөө" сэдэвт эссэ бичлэгийн, "Миний эх орон" сэдэвт гар зургийн уралдаануудыг зохион байгуулж нийт 14 хүн оролцож тэргүүлсэн болон оролцсон багш сурагчдыг Х.Намсрайжав агсны ач, зээ нар шагнаж урамшууллаа. ОНСТ-ын ажилтан Д.Дарханбаяр амьтдын үзмэрүүдийн хамгаалалтыг сайжруулах амьтдыг шимэгч хорхой шавьжнуудаас сэргийлэх зорилгоор салхилуулан ОНСТ-ын өрөө болон гэрэл тасалгааг шинээр будаж үндэсний хувцасны үзмэрт шилэн хорго засварыг хийж ажиллалаа.

Хүдэр сум:

Тайлант сард Засаг даргын зөвлөл 1 удаа хуралдаж цаг үеийн холбогдолтой асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Он гарсаар “Ковид-19” халдварын тохиолдол нэмэгдэж байна. суманд нийт 751 иргэн өвчилсөн байна. Одоогийн байдлаар 78 иргэн эмчлэгдэж байна. Аймаг, сумын онцгой комиссын гаргасан шийдвэрийг цаг тухай бүр хэрэгжүүлэн ажиллаж байна.



Анхдугаар Үндсэн хууль батлагдсан өдрийг тохиолдуулан Сэлэнгэ аймгийн Хүдэр сумаас АИХ-ын дедатутаар сонгогдож байсан Г.Хашбаатрын гэр бүлд хүндэтгэл үзүүлж Талархал гарын бэлгийг түүний хүү Х.Батбаатарт хүлээлгэн өглөө.

Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2016 оны А/133 дугаар тушаалаар батлагдсан “Ойгоос мод бэлтгэх журам”-ын хэрэгжилтийг хангуулах, хяналт шалгалтад хамрагдсан аж ахуй нэгжүүдэд илэрсэн зөрчлийг арилгуулах, мод бэлтгэсэн талбайн цэвэрлэгээг бүрэн гүйцэт хийлгэн актаар хүлээн авах талаар хугацаатай албан мэдэгдэл хүргүүлж 01 дүгээр сарын байдлаар 21 аж ахуйн нэгж мод бэлтгэсэн талбайн цэвэрлээг хүлээлгэн өгч байгаль хамгаалагч нар төгсгөлийн актаар хүлээн авч ажилласан.

Сумын Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт Байгалийн унаган төрх, тэнцвэрт байдлыг хадгалж, байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээхэд төр, ААН, байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, аялал жуулчлал, ногоон хөгжил сэдэвтэй 25 заалт бүхий ажил арга хэмжээний биелэлт, хэрэгжилтийн тайланг гарган сумын ИТХ-д өргөн барьж хэлэлцүүлсэн. Ойн санг гэрээгээр эзэмшигч байгалийн нөөцийн хамтийн менежментийн ойн нөхөрлөл, аж ахуй нэгжүүдийн 2021 онд Засаг даргатай байгуулсан Ойн сан эзэмших гэрээг сумын Засаг даргын 2022 оны А/01 тоот захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг нийт 33 ААН, 15 нөхөрлөл дүгнүүлж ажиллалаа.

Сумын Засаг даргын 2021 оны А/66 захирамжийн хүрээнд сумын хэмжээнд мах махан бүтээгдэхүүн худалдан борлуулдаг 5 иргэн, 3 шатахуун түгээх станцын үйл ажиллагаанд хяналт шалгалтыг зохион байгуулан 2021 оны махны үнийн судалгааг 2022 онтой харьцуулахад 1000-1500 төгрөгөөр өссөн дүнтэй байна.

Сумын Онцгой комиссын хуралдаанаас гарсан үүрэг чиглэлийг хэрэгжүүлэн Эрүүл мэндийн төв, сумын ЗДТГ хамтран суманд худалдаа үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 11 аж ахуй нэгж, иргэдийн 579 м2 талбайд ариутгал халдваргүйжүүлэлтийг хийсэн.

Малын эрүүл мэндийн гэрчилгээ олгох цахим системд 44 удаагийн гэрчилгээг цахимаар баталгаажуулж гарган, иргэдэд хөнгөн шуурхай үйлчилгээ үзүүлэн ажиллалаа. Үүнд адууны мах 690 кг, үхрийн мах 4181 кг, хонины мах 1100 кг, ямааны мах 2500 кг, гахайн мах 3кг, нийт 8474 кг, бодын шир 4 ширхэг, богийн арьс 125, сүү 242 л, аарц 10 кг, тус бүр эрүүл мэндийн гэрчилгээ олгож хяналт тавьсан.

Мал амьтны гоц халдварт шүлхий өвчний гаралт тархалтаас урьдчилан сэргийлэх аймгийн Онцгой комиссын 2021 оны 6192 тоот, аймгийн Засаг даргын А/101 тоот захирамж, сумын Засаг даргын А/167 дугаар захирамжуудийн хүрээнд салаа туурайтай мал амьтанг яаралтай дархлаажуулах ажил хийгдэж 21100 тун вакцин зарцуулан үхэр 10909, хонь 10296, ямаа 9324, гахай 281, бүгд 30810 толгой мал амьтан хамрагдлаа.

Цагааннуур сум:

Короновируст халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд сумын Онцгой комисс, Шуурхай штабын бие бүрэлдэхүүн өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт ажиллаж Засгийн газар, улс, аймгийн Онцгой комиссоос гаргасан албан даалгавар, тогтоол, шийдвэр, чиглэлийн дагуу ажиллаж байна. “Ковид-19”-ын халдвар нэмэгдэж байгаатай холбогдуулан аймгийн Онцгой комиссын шийдвэрээр сумын Эрүүл мэндийн төвд Ковидын тасаг ажиллуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.

Сумын Засаг даргын 2022 оны “Монгол Улсын Үндсэн хууль батлагдсаны 30 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх тухай” А/07 тоот захирамжаар батлагдсан төлөвлөгөөний дагуу Ардын Их Хурлын депутат, Монгол Улсын гавьяат Механикжуулагч Нацагийн Дэлгэрмөрөнд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчид болон Засаг дарга хүндэтгэл үзүүлсэн. Мөн Н.Дэлгэрмөрөнгийн нэрэмжит бүсийн Шатрын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулсан. Тэмцээнд эрэгтэй эмэгтэй нийт 22 тамирчин оролцож оюун ухаанаа сорин өрсөлдсөн.

“Шинэ нуур” ХХК үүсэн байгуулагдсаны 15 жилийн ойн хүрээнд суманд 15 сая төгрөгийн үнэ бүхий гурил хандивласныг сумын удирдлагын баг тус компанийн удирдлагатай зөвшилцөн Сар шинийн баярыг угтан сумын бүх ахмаднастан /55-аас дээш настай эмэгтэй, 60-аас дээш настай эрэгтэй/болох 493 иргэнд 1ш 25 кг гурил, шинэ оны хуанли болгон хүргэсэн. Сумын анхны 100 настан 1 ахмадад хүндэтгэл үзүүлж ууц, тавгийн идээг бэлэглэсэн.

2022 онд хийгдэх бүтээн байгуулалтын ажлын зураг төсвийг мэргэжлийн байгууллагуудаар хийлгэж төлөвлөгөөний дагуу тендерүүд зарлагдаж эхэлсэн.

Сумын Засаг даргын дэргэдэх зөвлөлийн хурлын шийдвэрээр Аварга тариаланчаар 2, аварга малчнаар 1, аварга сурагчаар 3, аварга ажилтнаар 2,

аварга мэргэжилтнээр 1, аварга Төрийн албан хаагчаар 1, худалдаа үйлчилгээний салбарын аварга ажилтан 1, сумын алдарт уяачаар 4 иргэнийг тус тус тодрууллаа.

Мал эмнэлгийн нэгдсэн цахим системд 01 дүгээр сарын байдлаар өдрийн хооронд нийт 196 гэрчилгээнд хяналт тавьж баталгаажуулсан. Халдваргүй өвчнөөр өвчилсөн 24 толгой мал, амьтанд эмчилгээ хийсэн.

Шаамар сум:

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 41 дүгээр тогтоолоор батлагдсан “Гэр бүл хүүхдэд ээлтэй орчин байх”, “Монгол бичиг” сумын дэд хөтөлбөрийг 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан төрийн байгууллагуудад хүргүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

01 дүгээр сард коронавируст /Ковид-19/-ийн халдварын 147 тохиолдол бүртгэгдсэн. Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг Шаамар ЗДТГ, Шаамарынхан, Шаамар ЕБС, Бид Шаамарынхан, Шаамар Эрүүл мэндийн төв, Шаамар Соёлын төв, Шаамар зар, Шаамар сум, Шаамар МСҮТ, Шаамар 1-р цэцэрлэг, Шаамар 2-р цэцэрлэг, Дулаанхаан сайхан нутаг зэрэг цахим хаягууд дээр байршуулан ажиллаж байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны “Бүх нийтийн ариутгал халдваргүйжүүлэлтийн эрчимжүүлэх тухай” А/15 тоот захирамжийн хэрэгжилтийн хүрээнд Шаамар сум Дулаанхаан тосгоны төр, төсвийн нийт 32, худалдаа үйлчилгээний 18 байгууллагын нийт 21586,2 м2 талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийж ажилласан.

Улаанбаатар хотод зохион байгуулагдаж байгаа “Цагаан сар-2022” үзэсгэлэн худалдаанд сумаас 2 аж ахуйн нэгжийг хамруулан зөгийн бал, зөгийн бусад бүтээгдэхүүнээр оролцож байна.

Малын гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэг тандалтыг Охиндий 2-р багийн 130 үхэр, Дэлгэрхаан 1-р багийн 70 үхэрт хийж ажиллалаа.

ХҮИ дугаар жарны “Буюн үйлдэгч” хэмээх усан Бар жилийн Хаврын тэргүүн сарын Сар шинийн баярын өдрийг тохиолдуулан орон нутагт амьдарч буй ахмад настнуудад харьяалах аж ахуй нэгж байгууллагууд хүндэтгэл үзүүлэх ажлын хүрээнд Дэлгэрхаан 1 дүгээр баг, Охиндий 2 дугаар багийн эрэгтэй 60, эмэгтэй 55 нас буюу түүнээс дээш 339 ахмад настны судалгааг гарган 42 аж ахуй нэгж байгууллага, 1 иргэнд хуваарилан холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгч ажиллалаа.

ХЯНАСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН

ГАЗРЫН ДАРГА

Ө.СУВДАА

НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИДЛАГЫН

ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

Д.АЛТАНТУЯА